

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020-2024 ОНЫ
БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААН ДАХЬ ЭДИЙН
ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН
ТАЙЛАН**

АГУУЛГА

БҮЛЭГ НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 2020-2024 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН 8

1.1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН..... 15

1.1.1 Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлт 15

1.1.2 Мөнгөний нийлүүлэлт, инфляц..... 17

1.1.3 Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, валютын ханш 20

1.1.4 Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл 24

1.2. САНХҮҮГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН..... 26

1.2.1. Банкны салбар 27

1.2.2. Хөрөнгийн зах зээл 31

1.2.3. Даатгалын зах зээл..... 34

1.2.4 Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай..... 36

1.2.5 Хадгаламж, зээлийн хоршоо 38

1.2.6 Монгол Улсын Хөгжлийн банк..... 39

1.3. ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН 41

1.3.1 Төсвийн ил тод байдлын үнэлгээ 43

1.3.2 Төсвийн гүйцэтгэл 44

1.3.3 Төсвийн орлогод баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт..... 45

1.3.4 Татварын бодлогын шинэчлэл, түүний үр дүнгийн тухай..... 46

1.3.5 Төсвийн урсгал зарлагад баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт болон авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэмжээ 50

1.3.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн тухай..... 54

1.3.7 Гадаад зээл, тусламжаар санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, хэрэгжүүлсэн арга хэмжээ, баримталсан зарчим, түүний үр дүнгийн тухай 60

БҮЛЭГ ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР, БОЛЗОШГУЙ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ, ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ӨР БА ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН ДҮН..... 64

2.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЗОРИЛТ 64

2.1.1 Засгийн газрын өрийн өнөөгийн байдал..... 65

2.1.2 Засгийн газрын дотоод үнэт цаас 66

2.1.3 Засгийн газрын гадаад үнэт цаас..... 67

2.1.4 Засгийн газрын гадаад зээл..... 68

2.1.5 Засгийн газрын өрийн баталгаа	70
2.1.6 Барих-шилжүүлэх төрлийн концесс.....	71
2.2. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР	72
БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ҮЛДЭГДЛИЙН НИЙТ ДҮН, ЭНЭ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ДАРААГИЙН ЖИЛИЙН ХУГАЦААН ДАХЬ ТУХАЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ҮНЭЛГЭЭ	75
3.1 ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД ШИЛЖҮҮЛСЭН ЭРДЭС, БАЯЛГИЙН ОРЛОГО, САНГИЙН ЗАРЛАГА.....	75
3.2 ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ХУРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	76
БҮЛЭГ ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ ДАРААГИЙН ЖИЛҮҮДИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮЗҮҮЛЭЛТ	78
БҮЛЭГ ТАВ. ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ	81
5.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ.....	81
5.2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ	82
5.3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ	83
БҮЛЭГ ЗУРГАА. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ НЬ УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛАГДСАН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ЭСХҮЛ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА ТАЛААРХ ТАЙЛБАР.....	85
6.1. ТӨСВИЙН БОДЛОГЫН ҮР ДҮН НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ /2020-2024/	85
6.2. ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙ ТАЛААР.....	88
6.3. ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛТЭЙ НИЙЦЭЖ БУЙ ТАЛААР.....	89

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	Азийн Хөгжлийн банк
ААН	Аж ахуйн нэгж
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн Банк
НХН	Нефть ханган нийлүүлэгч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОУВС	Олон Улсын Валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨБҮХХ	Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгө
ТТС	Төсвийн тогтворжуулалтын сан
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Эдийн засгийн өсөлт, хувиар	15
График 2. Инфляц, улирлаар, өмнөх оны мөн үеийн өөрчлөлт, 2020-2023	17
График 3. Мөнгөний нийлүүлэлт	19
График 4. Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам.доллар	20
График 5. Нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн дүн.....	20
График 6. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар.....	21
График 7. Төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш	23
График 8. Улс орнуудын мөнгөн тэмдэгтийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт, 2022-2023	23
График 9. Гадаад валютын албан нөөц, сая ам.доллар	23
График 10. Ажиллагсад, мянган.хүн.....	25
График 11. ААНБ-ын тоо, дундаж цалин.....	25
График 12. Нэг өрхийн сарын дундаж орлого, бүтцээр 2020-2023, мянган төгрөг	26
График 13. Нийт активын бүтэц, тэрбум төгрөг	28
График 14. Чанаргүй зээл, тэрбум төгрөг	28
График 15. Банкны салбарын пассивын үзүүлэлтүүд, тэрбум төгрөг.....	29
График 16. Үнэт цаасны компаниуд	31
График 17. Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг	31
График 18. Үнэт цаасны арилжааны хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр	32
График 19. Хөрвөх чадвар, хувиар	32
График 20. Даатгалын нягтрал болон даатгалын гүнзгийрэлт	34
График 21. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт, тэрбум төгрөг	35
График 22. МУХБ, балансын үзүүлэлт	39
График 23. Монгол улсын төсвийн ил тод байдлын үнэлгээ.....	43
График 24. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, тэрбум төгрөг	44
График 25. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, тэрбум төгрөг	44
График 26. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг	45
График 27. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, тэрбум төгрөг	53
График 28. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг	56
График 29. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны хэлбэр, 2012-2017..	66
График 30. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны үлдэгдэл, 2016-2023	67
График 31. Гадаад зээлийн ашиглалтыг салбар болон зориулалтаар, 2023.12.31-УГ	69
График 32. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, 2023.12.31 УГ тэрбум төгрөг	71

График 33. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын урьдчилсан төсөөлөл, тэрбум төгрөг.....	82
График 34. Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл, тэрбум төгрөг	83
График 35. Засгийн газрын өрийн хэмжээ, 2020-2023	87

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн.....	24
Хүснэгт 2. Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц ба эздийн өмч 2023 он, тэрбум төгрөг	35
Хүснэгт 3. Даатгалын компаниудын нөхөн төлбөр, тэрбум төгрөг	36
Хүснэгт 4. ББСБ-ын тоо, мэдээлэл	37
Хүснэгт 5. ББСБ-ын статистик мэдээлэл, сүүлийн 5 жилээр.....	37
Хүснэгт 6. ХЗХ-ын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд, тэрбум төгрөг	38
Хүснэгт 7. Хадгаламж, зээлийн хоршоодын статистик үзүүлэлтүүд.....	39
Хүснэгт 8. МУХБ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	40
Хүснэгт 9. МУХБ, Зээлийн эргэн төлөлт, өссөн дүнгээр	40
Хүснэгт 10. МУХБ, Эх үүсвэр төлөлт, өссөн дүнгээр.....	40
Хүснэгт 11. Гадаадын зээл, тусламжийн 2024 оны төлөвлөгөө, хөгжлийн түншээр, тэрбум төгрөг	62
Хүснэгт 12. Засгийн газрын өрийн бүтцээрх үлдэгдэл 2020-2023 он, тэрбум төгрөг	65
Хүснэгт 13. Гадаад үнэт цаас, 2023.12.31-УГ, тэрбум төгрөг.....	68
Хүснэгт 14. Гадаад зээлийн үлдэгдэл төрлөөр, 2019-2023.12.31 УГ, тэрбум төгрөг	69
Хүснэгт 15. Засгийн газрын баталгаа, 2023.12.31 УГ	70
Хүснэгт 16. ТТС-ийн орлого, зарлага, хуримтлал, тэрбум төгрөг.....	75
Хүснэгт 17. ТТС-ийн хуримтлал, тэрбум төгрөг	76
Хүснэгт 18. Сонгуулийн жилд гарсан шийдвэрийн төсөвт үзүүлэх нөлөөллийн хэмжээ, тэрбум төгрөг.....	78
Хүснэгт 19. Монгол Улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, 2025-2027.....	82
Хүснэгт 20. Төсвийн зардлын хэрэгцээний төсөөлөл, сая төгрөг	83
Хүснэгт 21. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, 2020-2024 он.....	85
Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-д эзлэх хувь	86
Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлт, хувиар.....	87
Хүснэгт 24. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл, ДНБ-д эзлэх хувь	88
Хүснэгт 25. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл, хувиар	88
Хүснэгт 26. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр, ДНБ-д эзлэх хувь	89

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 2020-2024 ОНЫ БҮРЭН
ЭРХИЙН ХУГАЦААНД ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН
ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

БҮЛЭГ НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 2020-2024 ОНЫ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААНД ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

ЦАР ТАХЛЫГ ДАВАН ТУУЛСАН 2020-2021 ОН. Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр олон улсад “цар тахал” гэж албан ёсоор зарласан ба халдварын тохиолдол 2021 оны эцэст дэлхий даяар нийт 280 гаруй саяд хүрч, 5.4 сая хүн нас барсан нь дэлхийн хоёрдугаар дайнаас хойш хүн төрөлхтөнд учирсан хамгийн том сорилт байлаа.

Коронавируст халдварт цар тахалтай тэмцэх арга замыг олох, халдварын эсрэг вакциныг гарах хүртэл улс орнууд халдварыг дотоодод алдахгүй байхын тулд хүн хоорондын зай барих, бизнесийн болон нийгмийн бүхий л үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчлэн зогсоох, БНСУ, Япон, Шведээс бусад бүх улс оронд хөл хорио тогтоож¹, ихэнх улс орнууд хилээ хаах арга хэмжээг хэрэгжүүлж, халдварын тархалтыг хяналтдаа авч байв.

Дэлхий нийтээр эдийн засгаа хаасан, урьдчилан тааварлашгүй нөхцөл байдлын улмаас 2020 онд АНУ-ын эдийн засаг 2.8 хувиар, Евро бүсийн эдийн засаг 6.1 хувиар, Японы эдийн засаг 4.3 хувиар агшиж, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2.2 хувь болж саарснаар 2-3 хувиар өсдөг байсан дэлхийн эдийн засаг -3.3 хувиар агшсан². Эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдуулан төсвийн орлого буурч, цар тахлын үеийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, орлогыг бууруулахгүй байх, хүнсний хангамжийн бодлогын нөлөөгөөр улс орон бүрт төсвийн алдагдал, өрийн хэмжээ өсөх явдал нийтлэг байв. Эдгээр сорилтууд манай улсыг ч мөн тойроогүй ба 2020 онд уул уурхайн салбар 9.9 хувиар, уул уурхайн бус салбар 3.7 хувиар буурч, нийт эдийн засаг 4.6 хувиар агшиж, төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 11.9 хувьд хүрч өсөхөд нөлөөлөв.

Монгол Улсын Засгийн газар үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан олон улсын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг яаралтай судалж, эрүүл мэндийн санхүүжилтийг нэмэгдүүлж бэлэн байдлыг хангах, иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлд цогц арга хэмжээнүүдийг шат дараатай хэрэгжүүлсэн. Үүнд: ажлын байрыг хадгалсан аж ахуйн нэгжүүдийг татвар, нийгмийн даатгалаас хөнгөлж, торгууль, алдангиас чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас 3 сар тэтгэмж олгох, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх татварын дэмжлэг үзүүлэх, 1.1 сая хүүхдийн мөнгөн тэтгэмжийг

¹ Аргентин улс хамгийн урт буюу 234 өдрийн хатуу хөл хорио тогтоосон.

² Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн төлөв тайлан

100 мянган төгрөгөөр олгож, халамжийн тэтгэврийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгох зэрэг арга хэмжээнүүдийг төсвийн хэмнэлттэй уялдуулан 2020 онд авч хэрэгжүүлж, иргэдийн ажлын байр, орлогыг хамгаалсан билээ.

2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр анхны дотоодын тохиолдол илэрч, Засгийн газраас дотооддоо халдварыг хяналтад авах боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Цар тахлын халдварын ид үед буюу 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн Засгийн газар байгуулагдав. Шинэ Засгийн газрын хамгийн эхний ажил нь Ковид-19 цар тахлын халдварыг тогтоон, бүх нийтийн вакцинжуулалтыг хийх замаар хаалттай байсан эдийн засаг, бизнесүүдээ нээх явдал байв.

Энэ хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хэрэгжүүлсэн КОВАКС хөтөлбөрт нийт 188 улс хамрагдсанаас Монгол Улс эхний ээлжид вакцинжуулалт авсан 18 улсын нэг болж Засгийн газар байгуулагдаад сар хүрэхгүй хугацаанд буюу 02 дугаар сарын 23-нд Монгол Улсад вакцинжуулалтыг албан ёсоор эхлүүлэв. Вакцинжуулалтыг эрчимжүүлэх зорилгоор сүүлчийн хатуу хөл хориог 2 долоо хоногийн хугацаанд тогтоож, иргэн бүрт 300 мянган төгрөгийн, вакцинд хамрагдсан хүн бүрт 50 мянган төгрөгийн нэг удаагийн урамшууллыг олгосноор зорилтот бүлгийн иргэдийн 90 гаруй хувийг вакцинжуулалтад хамруулж чадсан. Мөн Эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Ковид-19 өвчнийг эмчлэн эдгээсэн эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн тарифыг баталсан нь орны тоог богино хугацаанд огцом нэмэгдүүлэх хөшүүрэг болж, тус өвчнөөр нас баралтын хувь 0.21 буюу дэлхийн дунджаас 4.9 дахин бага гарахад нөлөөлөв. Үр дүнд нь Ази, Номхон далайн бүсийн улс орнуудаас бид 6-7 сарын өмнө хатуу хөл хориог суллаж, эдийн засгаа түрүүлж нээх боломжийг олгосон юм.

2020 онд хэрэгжүүлж байсан иргэдийн орлогыг хамгаалахад чиглэсэн төсвийн зарим арга хэмжээг 2021 онд үргэлжлүүлэн, эдийн засгаа нээсэнтэй зэрэгцэн иргэн, аж ахуйн нэгжүүд энгийн амьдралын хэмнэлдээ үе шаттайгаар шилжихэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж, арилжааны банкнуудын эх үүсвэрээр нийт 5.8 их наяд төгрөгийн зээлийг 72 мянган иргэн, аж ахуйн нэгжид олгож, нийт 176.9 мянган ажлын байрыг хадгалж чадсан. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны нэгдүгээр улиралд 54.9 хувьд хүрч түүхэн доод түвшинд хүрсэн ч оны эцэст 58.3 хувь болж нэмэгдэн, эдийн засаг өмнөх оноос 1.6 хувиар өсөж, төсвийн алдагдал ДНБ-ий 11.9 хувиас 6.7 хувьд хүрч буурсан.

ГЕОПОЛИТИКИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛЖ, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫГ ЭХЛҮҮЛСЭН 2022 ОН. Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахал бүрэн дарагдаагүй байсантай зэрэгцээд 2022 оны 02 сарын 24-нд ОХУ-

Украины зэвсэгт мөргөлдөөнөөс шалтгаалан нийлүүлэлтийн сүлжээ доголдож, дэлхий дахинд байгалийн хий, газрын тос, үр тарианы үнэ огцом өсөхөд нөлөөлөв. Үүнээс улбаалан улс орнуудад инфляц огцом нэмэгдэж, дараагийн томоохон сорилтыг бий болгосон. Тухайлбал, 2022 оны 7 дугаар сард АНУ-ын инфляцын түвшин 9.1 хувь буюу 1981 оноос хойших хамгийн өндөр түвшинд, 2022 оны 12 дугаар сард Их Британи улсын инфляцын түвшин 11 хувь буюу сүүлийн 40 жилд байгаагүй өндөр түвшинд хүрч өссөн байна.

Өндөр инфляцын дарамтын эсрэг хөгжингүй орнууд мөнгөний бодлогоо эрс хатууруулж, бодлогын хүүгээ нэмэгдүүлж эхлэв. Жишээлбэл, АНУ-ын Холбооны Нөөцийн Сангаас 2020 оны 3 дугаар сараас эхлэн 2 жилийн хугацаанд тогтмол 0.25 хувьтай байсан бодлогын хүүг 2022 оны 3 дугаар сараас эхлэн өнөөг хүртэл нийтдээ 11 удаа өсгөж 5.5 хувь буюу өндөр түвшинд хадгалсан нь хөгжиж буй орнуудын валютын ханш болон хөрөнгийн гадагшлах урсгалд томоохон цохилт болсон.

Импортын бараа бүтээгдэхүүнээс ихээхэн хамааралтай манай улсын хувьд гадаад эдийн засгийн үнийн огцом өсөлт шууд нөлөөлж, 2022 оны 6 дугаар сард гэхэд инфляцын түвшин 16.9 хувь болж сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн. Үүнээс гадна 2019–2021 онд ам.доллартой харьцах төгрөгийн ханш 2,775 төгрөг байсан бол 2022 оны төгсгөлд 21.0 хувь суларч 3,431 төгрөг болж төлбөрийн тэнцэл 2022 оны 8 дугаар сард 1.5 тэрбум ам долларын алдагдалтай гарсан.

Улмаар Засгийн газраас нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулахад чиглэсэн “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг 2022 оны 04 сарын 15-ны өдөр УИХ-аар батлуулж цаг алдалгүй хариу арга хэмжээ авч чадсан. Хуулийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн, гурил, мах, хүнсний ногоо, ургамлын тос зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах татварын болон санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Энэхүү арга хэмжээний хүрээнд дэлхий дахинд нефтийн бүтээгдэхүүний үнэ огцом өссөнтэй холбогдуулан “РОСНЕФТЬ” НХН-тэй газрын тосны бүтээгдэхүүн 25 хувиар хямдруулсан үнээр худалдан авах гэрээ байгуулж, гэрээ байгуулсан компаниудад нөөц бүрдүүлэхэд шаардлагатай зээлд 236.4 тэрбум төгрөгийн баталгаа гаргаж, 739 мян.тн дизель түлшний онцгой албан татвар, 447 мян.тн автобензины гаалийн албан татварыг хөнгөлснөөр түлш шатахууны нөөцийг бүрдүүлсэн нь нэг талаас гадаад валютын нөөцийг хамгаалах, нөгөө талаас инфляцыг тогтворжуулах чухал арга хэмжээ болсон.

Үүнээс гадна дотоодын гурил, махны боловсруулах үйлдвэрт нөөц бүрдүүлэх зорилгоор 17 төсөлд 88.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, Хөдөө аж ахуйг дэмжих зээлийн хүрээнд 1,515 зээлдэгчид 267.9 тэрбум

төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн дотоодод дангаар хангах боломжгүй цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнүүдийг импортолдог нийт 126 аж ахуйн нэгжийн 96 мян.тн бүтээгдэхүүнийг гаалийн албан татвараас чөлөөлж нөөц бүрдүүлсэн. Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд инфляцын түвшин 16.9 хувиас 2022 оны эцэст 13.2 хувь, 2023 оны эцэст 7.9 хувь хүртэл буурч Төв банкны зорилтот түвшинд хүрлээ.

Геополитикийн хүндрэлтэй зэрэгцэн БНХАУ-д Ковидын цар тахал эргэн нэмэгдсэнээр томоохон хотуудад хөл хориог 2022 оноос дахин хэрэгжүүлж, хилийн хорио цээрээ эрс чангалсан нь далайд гарцгүй манай улсын гадаад худалдаа, төсөв, санхүүгийн нөхцөл байдалд хүндээр нөлөөлөв. Тухайлбал, Гашуунсухайт боомтоор өдөрт хэвийн үеэс 4-5 дахин цөөн буюу 100 хүрэхгүй ачааны машин хилээр нэвтэрч, Шивээхүрэн, Булган, Замын-Үүд зэрэг боомтууд хаагдаж, 2022 оны эхний улиралд эдийн засаг 3.9 хувиар агшив.

Дээрх хүнд сорилтын цаг үед Монгол Улсын Засгийн газар Олон улсын валютын сангийн хөтөлбөрт хамрагдах эсхүл төсөв, мөнгөний зөв бодлогоор эдийн засгаа аврах хүндхэн сонголттой тулгарсан.

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО. Дэлхий нийтийг хамарсан урьдчилан тааварлах боломжгүй гадаад сорилт, бэрхшээлийг даван туулах цаг үетэй давхцан Монгол Улсын Их Хурлаас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлж, хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг цаг алдалгүй шийдвэрлэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зургаан чиглэл, 29 зорилт, 99 үйл ажиллагаа бүхий баримт бичгийг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан.

Шинэ сэргэлтийн бодлого нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар урт хугацааны зорилтуудыг хангаж, гадаад зах зээлийн аливаа сөрөг шокоос дархлаатай, урт хугацаанд тогтвортой, бие даасан эдийн засгийг бүтээхийг зорьсон хөгжлийн бодлого юм. Энэхүү бодлогоор эдийн засгийн хурдтай, хүртээмжтэй өсөлтийг хангахад саад болж буй олон жил тулгамдсан зургаан суурь асуудлуудыг тодорхойлж, цогцоор нь шийдвэрлэх зорилт тавьсан. Тэрхүү зургаан багц асуудлын хүрээнд боомт, эрчим хүч, аж үйлдвэр, хот хөдөөгийн тэнцвэр, ногоон хөгжил, төрийн бүтээмжийн сэргэлтийг эрчимжүүлж, салбарын хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүллээ.

2022 онд үүссэн хилийн хорио цээрийн нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас нэн тэргүүнд Боомтын сэргэлтийг эхлүүлж, Бээжингийн өвлийн олимпын үеэр БНХАУ-ын дарга Ши Жиньпин, Ерөнхий сайд Ли Кэчян нартай албан ёсны уулзалт хийж, 2 орны Засгийн газрын хамтарсан Ажлын хэсгийг байгуулан уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Уг арга

хэмжээний хүрээнд мөн Гашуунсухайт, Шивээхүрэн боомтод AGV автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминалыг байгуулж, зогсонги байдалд ороод байсан нүүрсний экспортыг богино хугацаанд хэвийн хэмжээнд хүргэж чадсан.

Мөн эдийн засгийн голлох боомтууд болох Замын-Үүд, Боршоо, Сүхбаатар боомтуудын барилга угсралт, цогцолборын байгууламжийн бүтээн байгуулалтыг амжилттай дуусгаж, цар тахлын үеэр хаалттай байсан авто замын бүх боомтуудын зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх ажлыг 2021 оны эхний улирлаас эхлэн 2023 онд багтаан хэрэгжүүлж дуусгалаа. Түүнчлэн, бараа эргэлтийн шинэ гарц болох “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 227 км, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн 233 км төмөр замуудыг тус тус ашиглалтад оруулсан.

Засгийн газраас экспортын орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарт тогтолцооны шинэчлэл хийх, ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр баталсан. Тогтоолын хүрээнд уул уурхайн биржийн тогтолцоог бий болгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах, оффтейк гэрээтэй холбоотой асуудлуудыг цэгцлэх зэрэг багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2021 онд 16.1 сая тонн байсан нүүрсний экспортын биет хэмжээ 2022 оны эцэст 31.7 сая тоннд хүрч өссөн бөгөөд үүний 65 хувийг оны сүүлийн 5 сард гаргажээ. Ингэснээр нийт экспорт 12.5 тэрбум ам доллар болж, 2022 оны 8 сард 2.7 тэрбум ам.доллар болж буураад байсан гадаад валютын улсын нөөцийг оны эцэст 3.4 тэрбум ам.долларт хүргэн нэмэгдүүлж, эдийн засгийг 5.0 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн.

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙГ ИЛ БОЛГОЖ, ӨСӨЛТИЙГ ӨРХӨД ЧИГЛҮҮЛСЭН 2023 ОН. Ашигт малтмалыг биржээр нээлттэй борлуулах хүрээнд “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль” 2022 оны 12 сарын 23-ны өдөр батлагдаж, 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлснээр биржээр нийт 15.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.5 их наяд төгрөгөөр арилжаалсан. Ингэснээр ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангаж, экспортын өгөөжийг нэмэгдүүлж чадлаа. Түүнчлэн гааль, татварын автомат бүрдүүлэлтийн системийг ашиглалтад оруулж, бүх төрлийн ашигт малтмалын экспортыг уг системээр дамжуулан хийж байгаа бөгөөд 2023 оны эцсийн байдлаар нийт 551 аж ахуй нэгжийн 6,679 ашигт малтмалын экспортын гэрээ хүчин төгөлдөр үргэлжилж байна.

Цаашлаад, Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой нууцад хамаарах гэрээний мэдээллийг нууцаас гаргаж, олон нийтэд ил тод болгож, экспортлогч компаниуд “уурхайн

ам” нөхцөлөөр гэрээ байгуулахыг зогсоож “хилийн үнэ” нөхцөлөөр гэрээ байгуулах шийдвэр гаргасан зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Эдгээр бодлогуудын үр дүнд нүүрсний экспортын хэмжээ 2023 онд 69.6 сая тоннд хүрч, нийт экспорт 2023 онд 15.2 тэрбум ам доллар болсноор түүхэн дээд хэмжээнд хүрч өслөө.

Гадаад худалдааны тэнцэл ийнхүү сайжирснаар 2010 оноос хойш анх удаа төсөв, төлбөрийн тэнцэл хоёулаа ашигтай гарч, гадаад валютын улсын нөөцийг 16 сарын дотор 2.7 тэрбумаас түүхэн дээд буюу 4.9 тэрбум ам.долларт хүргэв. Улмаар 2020 онд 4.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 12 хувьд хүрээд байсан төсвийн алдагдал 3 жилийн дотор 763.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувийн ашигтай гарч чадлаа. Дэлхий даяар инфляцын түвшин түүхэн дээд хэмжээнд хүрч, мөн БНХАУ-ын “Тэг Ковид” бодлого болон ОХУ, Украины дайны нөхцөл байдалтай хүнд үед ижил “В” зэрэглэлтэй орнуудаас хамгийн эхэнд олон улсын санхүүгийн зах зээлд “Сенчири-1,2,3” төслийг амжилттай хэрэгжүүлж, хугацаа тулсан Засгийн газар, МУХБ-ны гадаад бондын өрийн дарамтаас 2026 он хүртэл чөлөөлөгдөж, зээлжих зэрэглэлээ 2018 оноос хойш “В/тогтвортой” хэвээр хадгалж чадлаа.

Далд эдийн засгийг ил болгож, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжирсан боловч 20 сар дараалсан 2 оронтой инфляцын нөлөөгөөр иргэдийн бодит орлого, худалдан авах чадвар багагүй саарсан байв. Иймд Засгийн газраас орлогын дахин хуваарилалтаар ард иргэдийн орлого, амьжиргааг дэмжих зорилгоор Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үргэлжлүүлэн, 217 мянган төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцоог шинэчлэн нэмэгдүүлэн тогтоож, давхардсан тоогоор 147 мянган зорилтот халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 517 мянган өндөр настны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн. Дээрх бодлогын үр дүнд 2023 оны нэгдүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар буурч байсан өрхийн бодит орлого оны эцэст 14.1 хувиар нэмэгдэж, худалдан авах чадвар сайжирсан байна.

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ 2024 ОН. Шинэ сэргэлтийн бодлогын “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, 2024 оны төсвийн бодлогыг хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, хөдөө, орон нутагт төрийн үйлчилгээний хүртээмжийг, орон нутагт бизнес, үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглүүлээд байна. Энэхүү бодлогын арга хэмжээний хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлсэн.

Орон нутагт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд ипотекийн зээлийн хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 18 орчим хувийг орон нутагт олгодог байсныг 2024 оноос 50 хувьд хүргэж нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьшсан болон

орон нутагт анх удаа орон сууц худалдан авч буй иргэдэд зориулж урьдчилгаа төлбөрийн 60 хувийг төр батлан даах, орон нутагт орон сууц шинээр барьж борлуулсан, түрээслүүлсэн тохиолдолд орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх боломжийг нээгээд байна.

Цаашлаад, уламжлалт мал аж ахуйн тогтолцооноос хагас эрчимжсэн мал аж ахуйн тогтолцоонд шилжих, малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлж, мал аж ахуй, дайвар бүтээгдэхүүнээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цех мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх, ноос, арьс шир бэлтгэх, анхан шатны тордолт хийх, мал, малын гаралтай түүхий эдийн агуулах, зоорь ажиллуулах, мах, сүү бэлтгэх, боловсруулах зэрэг чиглэлд 60 хүртэлх сарын хугацаатай, 50 хүртэлх сая төгрөгийн хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтын зээл авах боломжийг бүрдүүлээд байна.


Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлогыг үе шаттай амжилттай хэрэгжүүлснээр боомтын нэвтрүүлэх хүчин чадал, бараа эргэлтийн хурдыг нэмэгдүүлж, экспортын хэмжээг 2 дахин өсгөж чадсан. Улмаар бүс тус бүр өөрийн онцлогт тохирсон эдийн засгийн төрөлжилтийг бий болгон, өрсөлдөх чадвараа сайжруулах нөхцөл бүрдлээ. Ингэснээр “Алсын хараа 2050”-д туссан эдийн засгийн дундаж өсөлтийг 6 хувьд хадгалах, дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн багтаамжийг 2 дахин тэлэх зорилтууд хангагдах, хөгжлийн мега төслүүд бодитой хэрэгжих суурь болох юм.

1.1. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

1.1.1 Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлт

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөөгөөр 2020 онд эдийн засаг 4.6 хувиар агшсан бол 2021 онд 1.6 хувиар, 2022 онд 5.0 хувиар, 2023 онд 7.0 хувиар тус тус өсөж, эдийн засгийн өсөлт тогтворжлоо.

График 1. Эдийн засгийн өсөлт, хувиар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хөдөө аж ахуйн салбар: Хөдөө аж ахуйн салбар нийт эдийн засгийн 13 орчим хувийг эзэлдэг ба үүний 90 орчим хувийг мал аж ахуйн салбар бүрдүүлдэг тул малын тооны өсөлт, бууралтаас өндөр хамаарал бүхий салбар болно.

2020 болон 2021 онд Хангайн бүсэд өвөлжилт хүндэрсний улмаас том малын зүй бус хорогдол өсөж, мал төллөлт буурсан нь салбарын өсөлтийг сааруулж байв. Харин 2022 онд малын хорогдол эрс буурч, нийт малын тоо анх удаа 71.1 сая толгойд хүрсэн нь хөдөө аж ахуйн салбарыг 12 хувиар өсгөж, эдийн засгийн өсөлтийг 1.7 нэгж хувиар дэмжив. Гэвч 2023 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэл, зудын нөхцөл байдлаас том малын зүй бус хорогдол 4.9 саяд хүрч өссөн нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг 8.9 хувиар бууруулж, эдийн засгийн өсөлтөд 1.3 нэгж хувиар сөрөг нөлөө үзүүлсэн.

Газар тариалангийн салбар нь хөдөө аж ахуйн салбарын 7-10 орчим хувийг бүрдүүлдэг ба 1,500 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 430-600 мян тн үр тариа, 120-200 мян тн хүнсний ногоо хураан авч дотоодын хэрэгцээг хангаж байна. Тус салбарын нэмэгдэл өртөг зэрэгцүүлэх үнээр 2020 онд 5 хувиар, 2021 онд 27 хувиар тус тус өссөн бол 2022 онд 11 хувиар буурсан.

Өнгөрсөн 2023 онд нийт тариалсан талбайн хэмжээ 642.2 мянган га-д хүрч 470 мян тн үр тариа, 179 мян тн төмс, 208 мян тн хүнсний ногоо хураан авчээ.

Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн 2023 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хураан авсан үр тариа 10 хувиар, хүнсний ногоо 40 хувиар тус тус өссөн нь салбарын өсөлтөд эергээр нөлөөлж байна. Нийт хураан авсан ургацыг байршлаар авч үзвэл Сэлэнгэ, Төв, Булган, Дархан-Уул, Хөвсгөл аймгууд үр тариа, төмсний 80 гаруй хувийг, хүнсний ногооны 70 орчим хувийг хангасан байна.

Уул уурхай, олборлолтын салбар: Уул уурхайн салбар нь нийт эдийн засгийн 20 гаруй хувийг дангаар бүрдүүлдэг салбар юм. БНХАУ-ын зарим томоохон хотуудад 2021 оны хагасаас КОВИД-19 цар тахлын халдвар эрчимтэй тархаж эхэлснээр урд хөрш хилийн хорио цээрээ эрс чангаруулсан нь манай улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, тээвэрлэлт, олборлолтод шууд нөлөө үзүүлсэн. Тухайлбал, Гашуунсухайт боомтоор өдөрт хэвийн үеэс 4-5 дахин цөөн буюу 100 хүрэхгүй ачааны машин хилээр нэвтэрч, Шивээхүрэн, Булган, Замын-Үүд зэрэг боомтууд хаалттай байсан нь гадаад худалдааны эрчмийг бууруулж, улмаар макро эдийн засгийн орчинд сөргөөр нөлөөлсөн.

Цар тахлын үеийн хориг, хязгаарлалтын онцгой нөхцөлд Монгол Улсын Засгийн газар БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагааг зохистой хэлбэрээр үргэлжлүүлэх, бараа тээвэрлэлтэд тулгарч буй асуудлуудаар зөвшилцөж, цар тахлын үед хэрэгжүүлэх “Ногоон гарц”-ын түр журмыг хэлэлцэн тохирсон.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайд Бээжингийн өвлийн олимпын үеэр хилийн “хорио цээрийг сулруулах, экспортыг эрчимжүүлэх, боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх” зэрэг арга хэмжээг цаг алдахгүй шийдэхийн тулд БНХАУ-ын дарга Ши Жиньпин, Ерөнхий сайд Ли Көчянтай албан ёсны уулзалт хийж, хоёр орны Засгийн газрын хамтарсан Ажлын хэсэг Боомтын сэргэлтийг эрчимжүүлж шалган нэвтрүүлэх гарцуудыг ашиглалтад оруулж, тээврийг оновчтой зохион байгуулснаар хилийн нэвтрүүлэлт нэмэгдэж, нүүрсний экспорт сэргэх эхлэл тавигдлаа.

Засгийн газраас боомтын сэргэлтийг эрчимжүүлж, хил гааль, тээврийн асуудлыг шийдвэрлэж, томоохон төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулсны үр дүнд 2021 онд 16.1 сая тн болж буураад байсан нүүрсний экспорт 2022 онд 31.8 сая тн буюу цар тахлын өмнөх үед хүрч, 2023 онд анх удаа 69.6 сая тн буюу цар тахлын өмнөх үеэс 2 дахин давж өслөө. Нүүрсний экспорт өссөнтэй холбогдуулан олборлолтын хэмжээ мөн 2022 онд 11 хувиар, 2023 онд 118 хувиар тус тус өссөн байна. Түүнчлэн 2023 оны 3-дугаар сард Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлснээр зэсийн баяжмал олборлолт 1,395 мянган тонн болж 17 хувиар өссөн байна. Ингэснээр уул уурхайн салбар 2023 онд 23.4 хувийн өсөлт үзүүлээ.

Аж үйлдвэр, барилгын салбар: Тус салбар 2021 онд 5 хувиар буураад байсан ч үйл ажиллагаа алгуур сэргэж 2022 онд 6.0 хувиар, 2023 онд 4.1 хувиар

тус тус өссөн. 2021 онд цар тахлын үеийн БНХАУ-ын “Тэг Ковид” бодлогоос шалтгаалан урд хөршөөс орж ирэх барилгын материал болон бусад шаардлагатай түүхий эд, материалын нийлүүлэлт тасалдаж, нөгөө талаас иргэдийн худалдан авах чадвар суларч эрэлт буурсантай холбоотойгоор шинэ барилга, бүтээн байгуулалтын ажил буурсан нь аж үйлдвэрийн салбарын бууралтад голлох нөлөө үзүүлжээ.

Харин 2022 онд авч хэрэгжүүлсэн импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулах, тээвэр, логистикийн үйл ажиллагааг оновчтой хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээний үр дүнд үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эд материалын нийлүүлэлт тогтворжин өсөлтийг хадгаллаа.


Үйлчилгээний салбар: КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор бүх төрлийн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа тасалдаж 2020 онд тус салбар 6.5 хувиар буурсан ба эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн нөлөөгөөр 2021 оноос үйлчилгээний салбарын үйл ажиллагаа аажмаар сэргэж 3.9 хувиар өссөн. 2022 оны сүүлийн хагасаас дотоод эдийн засгийн идэвхжил, өрхийн хэрэглээ нэмэгдсэний нөлөөгөөр худалдаа, тээвэр, үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтийг дэмжлээ.

Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2020 онд 37.4 их наяд, 2021 онд 43.6 их наяд, 2022 онд 53.9 их наяд, 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 68.9 их наяд төгрөг болж өслөө.

1.1.2 Мөнгөний нийлүүлэлт, инфляц

Инфляц. КОВИД-19 цар тахлаас улбаатай эдийн засгийн идэвхжил удааширч 2020 оны эцэст инфляцын түвшин 2.3 хувьд хүрээд байсан бол БНХАУ дах цар тахлын эсрэг хатуу хөл хорио, ОХУ-Украины геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэйгээр нийлүүлэлтийн гаралтай инфляц идэвхжиж 2022 оны 6 сард сүүлийн 10 жилийн дээд түвшин болох 16.9 хувьд хүрч өссөн. Инфляцын түвшинд нийлүүлэлтийн сүлжээний саатал болон газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалсан шатахуун, хүнс болон импортын бүтээгдэхүүний үнэ өссөн нь голлон нөлөөлж байв.

График 2. Инфляц, улирлаар, өмнөх оны мөн үеийн өөрчлөлт, 2020-2023



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Инфляцыг бууруулах, голлох бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эсрэг 2022 оны 4 дүгээр сард **“Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай”** хуулийг батлан дотоодын хүнс, импортын голлох хүнс, газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээл, гааль, онцгой албан татварын хөнгөлөлт, газрын тосны бүтээгдэхүүний хямдралтай үнийн гэрээ зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Түүнчлэн Төв банк бодлогын хүүг 2022 онд дараалан 5 удаа өсгөн 13 хувьд хүргэж инфляцыг бууруулах чиглэлд төсөв мөнгөний бодлогын уялдааг ханган ажилласны үр дүнд инфляцын хурд саарч 2023 оны эцэст 7.9 хувь болж Төв банкны зорилтот хэмжээнд хүрлээ.

*** “ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЗАРИМ, БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ, ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.**

ОХУ-Украины дайн, БНХАУ-ын “Тэг Ковид” хилийн хорио цээр, тээвэр логикийн саатал зэрэг олон улсын хямралт нөхцөл байдлын улмаас үүссэн үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2022 оны 04 сарын 15-ны өдөр “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталсан. Хуулийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн, гурил, мах, хүнсний ногоо, ургамлын тос зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх татвар, санхүүгийн дэмжлэгийг авч хэрэгжүүлсэн. Нэн тэргүүнд “Роснефть” НХН-тэй АИ-92 бензин тонн бүрийг 25 хувиар хямд авах хэлцэл хийж, нефть импортлогч 8 аж ахуй нэгжид 236.4 тэрбум төгрөгийн засгийн газрын баталгаа гаргасан. Түүнчлэн, 738.7 мянган тонн дизель түлшний 187.8 тэрбум төгрөгийн онцгой албан татварыг, 447.4 мянган тонн автобензиний 59.6 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг хөнгөлсөн байна.

Дотоодын хүнсний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх арга хэмжээний хүрээнд гурил махны боловсруулах үйлдвэрт 1 жилийн хугацаатай 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгосон. Арга хэмжээний үр дүнд 2022 оны эцсийн байдлаар нийт 17 төсөлд 88.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Мөн “Хөдөө аж ахуйг дэмжих зээл”-ийн эх үүсвэрийг 380 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1,515 зээлдэгчид 267.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ.

Түүнчлэн, элсэн чихэр, ёотон, хүнсний ургамлын тос, цагаан будаа зэрэг хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүнүүдийг гаалийн албан татвараас чөлөөлж нийт 126 аж ахуйн нэгжийн 96 мянган тонн импортын бүтээгдэхүүнийг 12.9 тэрбум төгрөгийн гаалийн албан татвараас чөлөөлсөн.

Энэхүү арга хэмжээний хүрээнд 2022 онд дэлхийн зах зээл дээр 400-460 долларт хэлбэлзэж байсан цагаан будааны үнэд кг тутамд 102.1 төгрөгийн дэмжлэг, 0.39-0.43 долларт хэлбэлзэж байсан элсэн чихрийн үнэд кг тутамд 99.5 төгрөгийн дэмжлэг, 2022 оны 3-5 дугаар сард 2000 доллар давж өсөөд байсан ургамлын тосны үнэд кг тутамд 299.8 төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлснээр импортын гол нэрийн барааны үнэ тогтворжсон байна.

Мөнгөний нийлүүлэлт. Мөнгөний нийлүүлэлт 2023 онд 37.6 их наяд төгрөгт хүрч, 2020 онтой харьцуулахад 53.5 хувиар өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд төгрөгийн харилцах 2.6 дахин, валютын харилцах 2.8 дахин, төгрөгийн хадгаламж 26.3 хувиар тус тус өссөн нь гол нөлөө үзүүллээ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө тус хугацаанд харьцангуй бага буюу 16.2 хувиар өссөн бөгөөд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх хэсгийг хадгаламж, харилцахын өсөлт бүрдүүллээ.

Нийт хадгаламжийн хэмжээ 2023 онд 22.1 их наяд төгрөгт хүрч, 2020 онтой харьцуулахад 21.1 хувиар өссөн бөгөөд иргэдийн хадгаламж 80.5 хувь, байгууллагын хадгаламж 19.5 хувийг тус тус бүрдүүлсэн байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд зээл, гадаад валютын нөөцийн өсөлт гол нөлөөг үзүүллээ.

График 3. Мөнгөний нийлүүлэлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

1.1.3 Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, валютын ханш

Гадаад худалдаа. Монгол улс 2020 онд нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны эргэлт 12.9 тэрбум ам.доллар байсан бол 2023 онд нийт 163 улстай худалдаа хийж, худалдааны эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрч 89.8 хувиар өслөө. Харин худалдааны тэнцэл 2020 онд 2.3 тэрбум ам.долларын ашигтай байсан бол 2023 онд 2.6 дахин өсөж 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

График 4. Гадаад худалдааны тэнцэл, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Экспорт: КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотойгоор хилийн боомтуудын үйл ажиллагаа удааширснаас үүдэн 2020 онд экспорт өмнөх оноос 0.6 хувь буюу 7.6 тэрбум ам.долларт хүрч буурсан. Цаашлаад цар тахлын нөхцөл байдал хүндэрч, 2021 оны эхэнд БНХАУ “Тэг Ковид” бодлого хэрэгжүүлж, хилийн хорио цээр чангарснаар манай улсын голлох уул уурхайн бүтээгдэхүүний экспорт зогсонги байдалд хүрч биет хэмжээ буурсан.

График 5. Нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн дүн



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Улмаар 2022 онд Засгийн газрын зүгээс тээврийг оновчтой зохион байгуулж, хилээр нэвтрэх машины тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авахын зэрэгцээ Засгийн газрын 362 дугаар тогтоолыг* баталж, экспортын орлогыг

нэмэгдүүлэх цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсний үр дүнд 2022 оны эхний хагаст 8 сая тонн байсан нүүрсний экспорт оны эцэст 31.8 сая тоннд хүрч нэмэгдсэн. Засгийн газраас 2023 онд уул уурхайн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд ашигт малтмалыг тээвэрлэх, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, уул уурхайн бүтээгдэхүүнийг биржийн үйл ажиллагааг эхлүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдүүдэд онцгой дэглэм тогтоож, компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлээ.

Үүний үр дүнд 2023 онд нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээндээ буюу 69.6 сая тоннд хүрч, экспортын орлого 15.2 тэрбум ам.доллар гарсан. Энэ нь 2020 оны экспортын орлоготой харьцуулахад 100.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Импорт: Ковид-19 цар тахлын үед эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа явуулах боломж хомс байсан тул импорт 2020 онд 5.3 тэрбум ам доллар болж 13.6 хувиар буурсан ба 2021 онд эргэн сэргэж 2019 оны түвшинд хүрэв. Гэвч 2022 оны 2 дугаар сард эхэлсэн ОХУ-Украины зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэн дэлхий даяар газрын тос, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх томоохон эрсдэлтэй тулгарсан. Улмаар Засгийн газраас шатахууны нийлүүлэлтийг тогтвортой хадгалах, импортын үнийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор “Роснефть” НХН-тэй газрын тосны бүтээгдэхүүнийг 25 хувиар хямдруулсан үнээр худалдан авах хэлцлийг байгуулж, нөөц бүрдүүлэх шат дараатай алхмуудыг шуурхай авч хэрэгжүүлснээр түлш, шатахууны төлбөрийг богино хугацаанд тогтворжуулахын зэрэгцээ, гадаад валютын нөөцөө хамгаалж чадсан юм.

Эдийн засгийн идэвхжил 2022 оны сүүлийн хагасаас сэргэж эхэлсэнтэй зэрэгцэн импорт 2022 онд 27.2 хувиар, 2023 онд 6.3 хувиар өсөв. Энэхүү өсөлтөд машин механик, тоног төхөөрөмж, түүний сэлбэг хэрэгсэл болон дизель түлшний импорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл 2020 оны эцэст 787 сая ам.долларын ашигтай байсан бол цар тахал, геополитикийн хүндрэлээс шалтгаалан 2021 онд 222 сая ам.долларын алдагдалтай гарсан. Харин 2022 онд экспортын бодит мөнгөн орлого буурсан нөлөөгөөр төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 оны 8 дугаар сард 1.5 тэрбум ам.долларт хүрч нэмэгдээд байв. Засгийн газраас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарч, 2022 оноос 2.2 тэрбум ам.доллараар, 2020 оны түвшнээс 670 сая ам.доллараар тус тус сайжирлаа.

Урсгал дансны тэнцэл 2020 онд 675 сая ам.долларын алдагдалтай байсан бол цар тахал, геополитикийн хүндрэлийн улмаас гадаад худалдааны тэнцэл буурсан, гадаад бонд, үнэт цаас, бусад зээлийн хүүгийн төлөлттэй холбоотойгоор урсгал дансны алдагдал

График 6. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2021 онд 2.1 тэрбум ам.доллар, 2022 онд 2.3 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2022 оны сүүлийн улирлаас эхлэн гадаад валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд гол уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнээр урсгал дансны тэнцэл 2023 онд 121 сая ам.долларын ашигтай гарлаа. Улмаар урсгал дансны тэнцэл 2007 оноос хойш анх удаа ашигтай гарсан.

Цар тахал, геополитикийн хүндрэлтэй үед гадаад өр төлбөрийн зохицуулалтыг амжилттай хийснээр төлбөрийн тэнцэлд үзүүлэх дарамт, өрийн дефолтын эрсдэлээс сэргийлж чадлаа. Тухайлбал, 2021 онд анх 2016 онд гаргасан “Мазаалай” бондын үлдэгдлийг, 2022 онд анх 2012 онд гаргасан “Чингис” бондын үлдэгдлийг тус тус төлж барагдуулсан.

Харин 2023 онд Монгол улсын Засгийн газраас анх 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын үлдэгдэл болох 387 сая ам.долларыг бүрэн төлж барагдуулсан бол МУХБ-наас анх 2018 онд гаргасан 500 сая ам.долларын “Евробонд”, 2013 онд гаргасан 30 тэрбум иений “Самурай” бондын төлбөрийг Хөгжлийн банк өөрийн эх үүсвэрээр амжилттай төлж барагдуулсан. Түүнчлэн 2023 оны 1 дүгээр сард 650 сая ам.долларын “Сенчири-2”, 12 дугаар сард 350 сая ам.долларын “Сенчири-3” бондыг олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаалсан. Улмаар 2024 онд төлөгдөх хуваарьтай “Хуралдай”, 2026 онд төлөгдөх хуваарьтай “Номад” бондын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтыг амжилттай хийлээ.

*** ЗАСГИЙН ГАЗРЫН 362 ДУГААР ТОГТООЛ.** Засгийн газраас эдийн засгийг тогтворжуулах, экспортын орлогыг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарт тогтолцооны шинэчлэл хийх, ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр баталсан. Тогтоолын хүрээнд гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох, уул уурхайн биржийн тогтолцоог бий болгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, ашигт малтмалын борлуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалттай холбоотой ил тод байдлыг хангах, оффтейк гэрээтэй холбоотой асуудлуудыг цэгцлэх зэрэг багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Улмаар 2022 оны 8 дугаар сард 2.7 тэрбум ам.доллар болж буураад байсан гадаад валютын улсын нөөц 2023 оны эцэст 4.9 тэрбум ам.доллар болж өмнөх оноос 45 хувиар өссөн.


Валютын ханш. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2019–2021 онд харьцангуй тогтвортой буюу дунджаар 2,775 төгрөг байсан бол 2022 оны сүүлийн сард оны эхнээс 20 хувь суларч 3,431 төгрөгт хүрсэн.

2015–2018 онд АНУ-ын Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүгээ нийт 9 удаа өсгөж 2.25-2.5 хувь болгон нэмэгдүүлсэн ч 2019 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед бодлогын хүүгээ 0.0-0.25 хувьд эргэн бууруулах шаардлагатай тулгарсан.

Харин цар тахлын дараа 2022 онд 9.1 хувьд хүрч өсөөд байсан инфляцыг бууруулах зорилгоор Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг дахин 11 удаа өсгөж 5.25–5.5 хувь болгосон. Энэ нь валютын болон хөрөнгийн зах зээлийг татах хүчин зүйл болж, улмаар валютын зах зээлд нийлүүлэлт хомсдон, ам.долларын өгөөжийг нэмэгдүүлснээр хөгжиж буй

улс орнуудад валютын ханшийн эрсдэл үүссэн. Тухайлбал, 2023 оны эцэст 2022 оны эхнээс ам.долларын эсрэг Туркийн лира 125 хувиар, Японы иен 23.0 хувиар, ОХУ-ын рубль 22 хувиар, БНХАУ-ын юань 11.0 хувиар, БНСУ-ын вон 8.0 хувиар тус тус суларчээ.

График 9. Гадаад валютын албан нөөц, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

График 7. Төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш



Эх сурвалж: Монголбанк

График 8. Улс орнуудын мөнгөн тэмдэгтийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт, 2022-2023



Эх сурвалж: Монголбанк, Bloomberg

2022 оны 8 дугаар сард гадаад валютын нөөц 2.7 тэрбум ам.доллар болж, сүүлийн дөрвөн жилийн доод түвшинд хүрээд байсан билээ. Монгол Улсын Засгийн газар эдийн засгийг

тогтворжуулах, гадаад валютын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд, 2022 оны 10 дугаар сард “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 362 дугаар тогтоолыг баталж уул уурхайн салбарын үйл ажиллагааг ил тод болгож, ашигт малтмалыг биржээр арилжиж эхэлснээр экспортын орлого нэмэгдсэн. Ингэснээр 2023 оны эцэст гадаад валютын нөөц 4.9 тэрбум ам.доллар болж импортын 6.4 сарын хэрэглээг хангах түвшинд хүрсэн ба төгрөгийн ханш тогтворжин, сарын дундаж ханш 3,421 болж оны эхнээс 1.3 хувиар чангарсан байна.

1.1.4 Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл

Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 2020 оны 4 дүгээр улиралд 1,216.6 мянга нь ажиллах хүч, 918.1 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байсан бол 2023 оны мөн үед ажиллах хүч 2.4 хувиар буюу 30 мянгаар нэмэгдэж 1,246 мянгад хүрсэн бол, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 2 мянгаар буурч 915.9 болжээ.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

	2020-IV	2021-IV	2022-IV	2023-IV
Ажиллах хүч	1,217	1,227	1,223	1,246
Ажиллагчид	1,125	1,127	1,158	1,197
Ажилгүй хүн	92.1	99.4	64.6	48.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	918.1	878.2	888.1	915.9
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	57.0	58.3	57.9	57.6
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	52.7	53.6	54.9	55.4


Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Ажиллагсад: Аж үйлдвэрийн салбарын ажиллагсад цар тахлын үеийн түвшнээс 25 хувиар буюу 50 мянгаар нэмэгдэж 2023 оны 4 дүгээр улиралд 225 мянгад хүрсэн нь бусад салбаруудтай харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй байна.

Монгол Улсын Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2021-2022 онд 5 хөтөлбөр, 17 арга хэмжээг хэрэгжүүлсэн бол 2022-2023 онд нийт 7 хөтөлбөр болж, 28 арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Энэхүү хөтөлбөрүүд нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг дэмжихэд чиглэж байна. Тухайлбал “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-үүдийг батлан хэрэгжүүлсэн байна.


График 10. Ажиллагсад, мянган.хүн



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Цалин, хөлс: 2020 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин 1,328 мянган төгрөг байсан бол 2023 оны мөн үед ажиллагчдын сарын дундаж цалин 68.3 хувиар буюу 907 мянгаар нэмэгдэж 2,235 мянга болсон байна.

График 11. ААНБ-ын тоо, дундаж цалин



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо


Үйл ажиллагаа явуулж буй

ААНБ-ын тоо 2020 оны 4 дүгээр улиралд 76 мянга байсан нь 2023 оны мөн үед 26.8 хувиар буюу 20 мянгаар өсөж 96 мянга болжээ.

Өрхийн орлого: Нэг өрхийн нэрлэсэн сарын дундаж орлого 2020 оны 4 дүгээр улиралд 1,425 мянган төгрөг байсан бол 2023 оны 4 дүгээр улиралд 2,286 мянган төгрөг болж, 862 мянган төгрөгөөр өссөн. Өрхийн орлогын бодит өөрчлөлтийг харахад үнийн нөлөөллийг арилгадаг. Үнийн өсөлтийн нөлөөллийг арилгасан өрхийн бодит орлого 2023 оны 4 дүгээр улиралд 2020 оныхоос 16.1 хувиар нэмэгдсэн байна. Тус өсөлтийг бүтцээр нь задалбал цалингийн орлого 10.8 нэгж хувийг, тэтгэвэр тэтгэмж 3.3 нэгж хувийг, ХАА-н

үйлдвэрлэлийн орлого 1.6 нэгж хувийн өсөлтийг бий болгох нөлөө үзүүлсэн байна.

График 12. Нэг өрхийн сарын дундаж орлого, бүтцээр 2020-2023, мянган төгрөг



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

1.2. САНХҮҮГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газраас санхүүгийн бодлогын хүрээнд банкны салбар, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хууль эрх зүйн орчинд дараах шинэчлэлүүдийг хийлээ. Үүнд:

Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжсэн байхаар тус тус зохицуулалт хийсэн. Улмаар, системийн том 5 банк олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, 478.5 тэрбум төгрөгтэй тэнцэж хэмжээний эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. Арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй хэлбэрт амжилттай шилжсэнээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, засаглалын хувьд илүү ил тод, нээлттэй болж, банкны салбар, хөрөнгийн зах зээл өргөжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын банк, санхүүгийн салбарт гаднын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Энэхүү хуулиар хөрөнгө оруулалтын чиглэлээр төрөлжсөн банк байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Ингэснээр мега төсөл

хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бизнест сонирхолтой гаднын хөрөнгө оруулагч нарт шинэ боломжийг нээж өгсөн байна.

Улсын Их хурлаас баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн нүүрсний цахим арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан нээлттэй арилжаалж эхэлсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан. Хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн хоорондын уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг эерэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болох ач холбогдолтой юм.

1.2.1. Банкны салбар

Банкны салбарт 2023 оны жилийн эцсийн байдлаар 13 арилжааны банк 1,397 салбар нэгж, 16,459 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо давхардсан байдлаар 2019 онтой харьцуулахад 0.3 хувиар өсөж 3.3 сая иргэн, ААН болж, нийт зээлдэгчдийн тоо 2019 онд 1.4 сая байснаас 2023 онд 1.8 саяд хүрч 22.4 хувиар нэмэгдсэн байна.

Банкнудын олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2019 онд 16.9 хувь байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 16.0 хувь болж 0.9 хувиар буурч валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 10.1 хувь болсон байна.

Активын бүтэц, өөрчлөлт. Банкны салбарын нийт активын хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 57.1 их наяд төгрөгт хүрч, 2019 онтой харьцуулахад 59.1 хувиар буюу 21.4 их наяд төгрөгөөр нэмэгдэж, ДНБ-ний 82.9 хувьд хүрээд байна.

График 13. Нийт активын бүтэц, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк

Нийт активын 44.6 хувь нь зээл, 16.9 хувь нь банкны нөөц, 2.7 хувь нь Засгийн газрын авлага, 15.3 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 20.5 хувь нь бусад хөрөнгө байна (гадаад актив, үнэт цаас, бусад санхүүгийн байгууллагаас авах авлага, ӨБҮХХ,

дериватив, үндсэн, биет бус хөрөнгө, үнэт металл). Банкны салбарын зээлийн хэмжээ 2023 оны эцэст 25.4 их наяд төгрөгт хүрч, 2019 оноос 51.7 хувиар буюу 8.7 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

Банкны салбарт 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 27,416.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 23,670.5 тэрбум төгрөг буюу 86.3 хувь нь хэвийн ангилалд, 1,263.1 тэрбум төгрөг буюу 4.6 хувь нь хугацаа хэтэрсэн ангилалд, 1,732.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувь чанаргүй зээлд тус тус ангилагдсан байна. Зээлийн чанарыг 2019 онтой харьцуулахад чанаргүй зээлийн хэмжээ 299.6 тэрбум төгрөгөөр буюу 17.3 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 443.8 тэрбум төгрөгөөр буюу 35.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

График 14. Чанаргүй зээл, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк


Чанаргүй зээл
2023 оны байдлаар 2019 онтой харьцуулахад 299.6 тэрбум төгрөгөөр өссөн боловч нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2019 онд 7.9 хувь байсан бол 2023 онд 6.3 хувь болж 1.6 хувиар буурсан байна.

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл цалингийн зээл 4.2 их наяд төгрөг буюу нийт зээлийн 15.6 хувь, үл хөдлөх хөрөнгийн салбарт 3.9 их наяд төгрөг буюу нийт зээлийн 15.5 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 5.4 их наяд төгрөг буюу нийт зээлийн 20.0 хувь, барилгын салбарт 1.8 их наяд төгрөг буюу нийт зээлийн 6.8 хувь, боловсруулах салбарт

2.0 их наяд төгрөг буюу нийт зээлийн 7.4 хувь, уул уурхайн салбарт 1.4 их наяд төгрөг буюу нийт зээлийн 5.2 хувь тус тус олгогдсон байна.

Пассивын бүтэц, өөрчлөлт. Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2023 онд 50.9 их наяд төгрөгт хүрч, 2019 оноос 18.9 их наяд төгрөгөөр буюу 58.9 хувиар өссөн нь Ковидын цар тахлын үед төр, засгаас хэрэгжүүлсэн “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжсэн зэргээс шалтгаалсан байна. Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ оны эцсийн байдлаар 6.2 их наяд төгрөгт хүрч, 2019 оноос 2,485.1 тэрбум төгрөгөөр буюу 67.2 хувиар нэмэгдлээ.

График 15. Банкны салбарын пассивын үзүүлэлтүүд, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын бодлогын арга хэмжээ. Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжсэн байхаар тус тус зохицуулсан.

Олон улсын валютын сангийн ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон бусад албаны хүмүүстэй уулзалт хийж олон улсад үүсээд буй улс төр, эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал болон Монгол Улсын нийгэм, эдийн засгийн талаар санал солилцсон. Тус уулзалтын хүрээнд банкнуудад активын чанарын үнэлгээг хийж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг нарийвчлан тогтоосны үндсэн дээр Банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах нь зүйтэй талаарх зөвлөмжийг өгсөн. Мөн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 05 дугаар тогтоолоор системийн нөлөө бүхий банкнуудыг нээлттэй

хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хугацааг сунгах зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх чиглэлийг Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн.

Үүний дагуу “Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд заасан хугацааг 1 жилээр хойшлуулж “2023 оны 06 дугаар сарын 30”-ны өдөр болгон 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд системийн том 5 банк олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, IPO амжилттай хийгээд байна. Арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй хэлбэрт амжилттай шилжсэнээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, засаглалын хувьд илүү ил тод, нээлттэй болж, банкны салбар, хөрөнгийн зах зээл өргөжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж нөхцөлийг бүрдүүлсэн.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль. Монгол Улсын банк, санхүүгийн салбарт гаднын хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх, санхүүгийн салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Энэхүү хуулиар хөрөнгө оруулалтын чиглэлээр төрөлжсөн банк байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Ингэснээр мега төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хэлбэрээр үйл ажиллагаа явуулах бизнест сонирхолтой гаднын хөрөнгө оруулагч нарт шинэ боломжийг нээж өгсөн.

Гадаадын банкны салбар нэгжийг Монгол улсад нэвтрүүлэх. Улсын Их Хурал (УИХ)-ын чуулганы 2023.11.23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, баталсан.

Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, банкны салбарын тогтвортой өсөлтийг хангана. Банкнуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох эрсдэлүүдийг дотооддоо үнэлэх тогтолцоог бүрдүүлэхээр тус үндсэн чиглэлд тусган батлагдсан болно.

1.2.2. Хөрөнгийн зах зээл

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 602 хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаагаас мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаасны компани 52, үнэт цаасны арилжаа эрхлэх 3, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын 10 этгээд тус тус үйл ажиллагаа явуулж байна.


График 16. Үнэт цаасны компаниуд



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлт. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн нийт актив хөрөнгө 2023 оны жилийн эцсийн байдлаар 74.9 их наяд төгрөг байгаагаас хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 11.7 их наяд төгрөг буюу санхүүгийн зах зээлийн 15.6 хувийг эзэлж байна.

График 17. Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөг




Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 11.6 их наяд төгрөг болж, ДНБ-ний 16.9 хувьтай тэнцэх болсон нь Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар системд нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаа гаргах замаар нээлттэй

хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шийдвэртэй холбоотой юм.


Үнэт цаасны зах зээл: Үнэт цаасны зах зээл дээр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 787.2 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаа хийгдсэн бөгөөд үүнээс 524.8 тэрбум төгрөг буюу 66.7 хувийг хувьцаа, 138.1 тэрбум төгрөг буюу хувийг компанийн бонд, 63.5 тэрбум төгрөг буюу 8.1 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 60.8 тэрбум төгрөг буюу хувийг Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа бүрдүүлэв.

График 18. Үнэт цаасны арилжааны хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

График 19. Хөрвөх чадвар, хувиар



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 77.42 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Хөрвөх чадвар: Хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар 2023 оны жилийн эцсийн байдлаар 1.5 хувь болж 2019 онтой харьцуулахад 1.9 пунктээр буурсан байна. Монгол улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2023 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль. Улсын Их хурлаас баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор баталсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн нүүрсний цахим арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан нээлттэй арилжаалж эхэлсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба 2023 онд тус биржээр нийт 15.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 7.54 их наяд төгрөгөөр арилжаалсан байна. Манай улсын хувьд 2023 оны байдлаар нийт 69.6 сая тонн нүүрс болон 5.7 сая тонн төмрийн хүдэр баяжмалыг экспортолсон байна. Үүнээс нүүрсний

экспортын 21.5 хувь, төмрийн хүдэр, баяжмалын 11.7 хувийг тус тус уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан байна.

Банкны салбарын реформ. Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар системд нөлөө бүхий банкууд компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулж, хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаа гаргах замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болох, мөн хувьцаа эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах үүргийг тус тус хүлээсэн.

Үүний үр дүнд “Богд банк” ХК болон системд нөлөө бүхий 5 банк болох “Төрийн банк” ХК, “Голомт банк” ХК, “ХААН банк” ХК, “Худалдаа Хөгжлийн банк” ХК, “Хас банк” ХК-ийн IPO хийх ажиллагаа амжилттай хэрэгжсэн. Нийт давтагдсан тоогоор 72 мянга гаруй хөрөнгө оруулагчдаас 478.54 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлснээс гадна зах зээлийн үнэлгээг 5.86 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Үнэт цаасны зэх зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо хариуцан боловсруулахаар тусгасан. Энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс боловсруулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэх Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газар хэлэлцэж, Улсын Их Хуралд 2023 оны 12 дугаар сард өргөн мэдүүлсэн.


Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дотоодын аж ахуйн нэгжээс нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагаа хялбар, шуурхай болж, зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн хоорондын уялдаа холбоо сайжран олон улсын жишигт нийцэх, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх, үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниудын үүрэг оролцоо өсөх, үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг эерэг нөлөө хөрөнгийн зах зээлд бий болох ач холбогдолтой юм.

1.2.3. Даатгалын зах зээл

Даатгалын зах зээл дээр 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 2 компани, давхар даатгалын 1 компани, даатгалын 63 зуучлагч, даатгалын 24 хохирол үнэлэгч, даатгалын 2416 төлөөлөгч, 40 актуарч, даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын 45 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын гүнзгийрэлт, даатгалын нягтрал нь олон улсын дунджаас харьцангуй доогуур үзүүлэлттэй хэвээр байна. Тухайлбал, 2023 оны байдлаар даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-ийн 0.79 хувьтай тэнцүү байна.

График 20. Даатгалын нягтрал болон даатгалын гүнзгийрэлт




Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Хөрөнгө, хураамжийн орлого. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 551.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 185.6 тэрбум төгрөг буюу 50.74 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого, түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн эзлэх хувийг салбарын хэмжээнд авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 85.1 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 12.0 хувь, урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 3.0 хувийг тус тус эзэлж байна.

Даатгалын компаниуд 2023 онд нийт 398.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлснээс ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 392.0 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласан байна. Үүний 388.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг буюу 99.2 хувийг ердийн даатгалын компаниуд, 3.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг буюу 0.8 хувийг урт хугацааны даатгалын компани тус тус бүрдүүлсэн байна.

График 21. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлт, тэрбум төгрөг



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Өр төлбөр, нөөц сан, эздийн өмч. 2023 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт өр төлбөр 26.4 тэрбум төгрөгт, даатгалын нөөц сан 79,2 тэрбум төгрөгт, эздийн өмч 173.8 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Ердийн даатгалын компаниудын хувьд нийт өр төлбөр ба эздийн өмчийн 9 хувийг өр төлбөр, 31 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц, 16 хувийг нөхөн төлбөрийн нөөц сан, 44 хувийг эздийн өмч тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 2. Даатгалын компаниудын өр төлбөр, нөөц ба эздийн өмч 2023 он, тэрбум төгрөг

Компани	Өр төлбөр	Нөөц сан	Эздийн өмч	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц
Ердийн даатгалын компани	286.7	234.4	182.3	175.0
Урт хугацааны даатгалын компани	3.9	3.1	12.6	-
Давхар даатгалын компани	35.0	31.4	30.9	-
Нийт	325.6	268.9	225.8	175.0

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нөхөн төлбөр, хохирлын харьцаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт даатгалын нөхөн төлбөр 126.7 тэрбум төгрөгт хүрсэн нь 2019 оны мөн үеэс 93.4 хувиар өссөн байна. Мөн 2023 онд давхар даатгагчийн нөхөн төлбөр 5.8 төгрөгт хүрсэн ба хөрөнгийн болон мал, амьтдын даатгалын нөхөн төлбөрт 5.0 гаруй тэрбум төгрөг олгосон байна. Нийт хохирлын харьцаа ердийн даатгалын компаниудын хувьд 55.5 хувь, урт хугацааны даатгалын компанийн хувьд 72.7 хувь, давхар даатгалын компаниудын хувь 141.7 хувь байна.

Хүснэгт 3. Даатгалын компаниудын нөхөн төлбөр, тэрбум төгрөг

№№	Даатгалын компанийн төрөл	Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	Салбарт эзлэх хувь
11	Ердийн даатгалын компани	118.8	93.8%
22	Урт хугацааны даатгалын компани	2.1	1.7%
33	Давхар даатгалын компани	5.8	4.6%
Нийт		126.7	100 %

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Албан журмын даатгал. 2023 онд ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлж 46.9 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн нь даатгалын хураамжийн орлогын 12.1 хувийг эзэлж байна. Мөн жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нь сүүлийн 5 жилийн дунджаар ердийн даатгалын нийт хураамжийн орлогын 15.5 хувийг, нийт нөхөн төлбөрийн 31.1 хувийг, нийт байгуулагдсан гэрээний 56.0 хувийг, нийт нөхөн төлбөр олгогдсон гэрээний 45.2 хувийг тус тус бүрдүүлж байна.

ДААТГАЛЫН САЛБАРЫН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Хууль эрх зүйн орчин. Даатгалын салбарт тулгамдаж буй заавал даатгалын буюу хохирогчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангуулах, түүнд тавих хяналтыг сайжруулах, гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, даатгалын компаниудын хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, дотоодын давхар даатгалын тогтолцоог дэмжих зорилгоор Даатгалын тухай, Даатгалын зуучлалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, батлуулахаар ажиллаж байна.

1.2.4 Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай

Тус хуулийн дагуу нийт 529 банк бус санхүүгийн байгууллага 2023 онд үйл ажиллагаа явуулж байгаагаас 95 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулдаг, 24 банк бус санхүүгийн байгууллага гадаадын хөрөнгө оруулалттай, 5 банк бус санхүүгийн байгууллага олон нийтэд хувьцаагаа санал болгосон байна. Түүнчлэн 529 ББСБ-ээс 90.4% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг, үүний 54.6% нь дагнасан зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Хүснэгт 4. ББСБ-ын тоо, мэдээлэл

	2019	2020	2021	2022	2023
Нийт ББСБ	538	532	534	513	529
Хөдөө орон нутаг	75	77	83	93	95
Гадаад хөрөнгө оруулалт	27	30	28	26	24
Салбар	250	295	331	427	446
Төлөөлөгч	7	9	8	8	11

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нийт ББСБ-ын 29.9 хувийг гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 158 банк бус санхүүгийн байгууллага байгаагаас 48 банк бус санхүүгийн байгууллага нь гадаад валютын үйл ажиллагаа дагнан эрхэлж байна.

Хүснэгт 5. ББСБ-ын статистик мэдээлэл, сүүлийн 5 жилээр

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023	Өөрчлөлт	
						Дүн	Хувиар
Хувьцаа эзэм/н тоо	7,712	8,869	21,793	26,993	30,419	3,426	12.7%
Ажилчдын тоо	2,962	3,437	3,976	4,554	5,009	455	10.0%
Харилцагчдын тоо	2,854	2,844	4,820	4,633	4,535	-97.9	-2.1%
Зээлдэгчдийн тоо	419	788	1,678	1,187	1,600	412	34.8%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.0%	2.8%	2.7%	3.1%	3.3%	+0.2 пункт	

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 30,419-д хүрсний 96.6 хувь нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-ын хувьцаа эзэмшигчид, 3.4% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 8.9% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын хувьцаа эзэмшигчид, 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-ын хувьцаа эзэмшигчид байна.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд: ББСБ-ын нийт актив 4,672.2 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 2,745.3 тэрбум төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгө 1,498.0 тэрбум төгрөг, нийт зээл 3,675.9 тэрбум төгрөг тус тус хүрсэн байна. Активын өсөлтийн 83.2 хувийг нийт зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 51.6 хувийг өр төлбөрийн, 48.4 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Ашигт ажиллагаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-д 1,163.8 тэрбум төгрөгийн орлого олж, 731.7 тэрбум төгрөгийн зардал гаргаж 432.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 30,419 хувьцаа эзэмшигчдийн 529 банк санхүүгийн байгууллагууд тэдгээрийн 446 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар, 5,009 ажилтантайгаар Монгол Улсын 21 аймаг, 9

дүүрэгт давхардсан тоогоор 4.5 сая харилцагч, 1.6 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

1.2.5 Хадгаламж, зээлийн хоршоо

Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 191 хадгаламж, зээлийн хоршоо 2023 онд үйл ажиллагаа явуулснаас 47.6 хувь нь хөдөө орон нутагт, 52.4 хувь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Хадгаламж, зээлийн хоршоод нь нийт 72,521 гишүүдтэй байгаагаас 0.4 хувь нь хуулийн этгээд, 54.4 хувь нь эмэгтэй гишүүд байна.

Хүснэгт 6. ХЗХ-ын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд, тэрбум төгрөг

Үндсэн үзүүлэлтүүд	2023
Нийт хөрөнгө	306.5
Нийт зээл	209.1
Нийт чанаргүй зээл	6.7
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.2%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	215.6
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	27.5
Нийт хоршоодын өмч	41.8

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт хөрөнгө 2023 оны жилийн эцсийн байдлаар 306.4 тэрбум төгрөг, нийт зээлийн үлдэгдэл 209.08 тэрбум төгрөг, чанаргүй зээл 6.6 тэрбум төгрөг, татан төвлөрүүлсэн хадгаламж 215.6 тэрбум төгрөг болсон байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу нийт 14 Хадгаламж, зээлийн хоршоо 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлж, хуулийн хэрэгжилтийг ажилласан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 191 хадгаламж, зээлийн хоршоо 2023 онд үйл ажиллагаа явуулснаас 47.6 хувь нь хөдөө орон нутагт, 52.4 хувь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Хадгаламж, зээлийн хоршоод нь нийт 72,521 гишүүдтэй байгаагаас 0.4 хувь нь хуулийн этгээд, 54.4 хувь нь эмэгтэй гишүүд байна.

Хүснэгт 7. Хадгаламж, зээлийн хоршоодын статистик үзүүлэлтүүд


Статистик үзүүлэлт	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт гишүүдийн тоо	72,521	100.0%	39,284	54.2%	33,237	45.8%
Гишүүн хуулийн этгээд	268	0.4%	198	73.9%	70	26.1%
Нийт ажилтнуудын тоо	1,035	100.0%	376	36.3%	659	63.7%
Санхүүгийн программтай	90	47.1%	37	41.1%	53	58.9%
20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-ын тоо	14	100.0%	12	85.7%	2	14.3%

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

1.2.6 Монгол Улсын Хөгжлийн банк

Хөгжлийн банкны актив 2020 оны жилийн эцсийн байдлаар 4,194.4 тэрбум төгрөг, зээлийн үлдэгдэл 2,802.6 тэрбум төгрөг, эзэмшигчийн өмч 998.6 тэрбум төгрөг, алдагдал 86.1 тэрбум төгрөг байсан бол 2024 оны 3 дугаар сарын байдлаар нийт актив 2,507.1 тэрбум төгрөг, зээлийн үлдэгдэл 2,227.2 тэрбум төгрөг, эзэмшигчийн өмч 718.5 тэрбум төгрөг байна.

График 22. МУХБ, балансын үзүүлэлт



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн Банк

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд эрчим хүчийг дотооддоо үйлдвэрлэж, хэрэглэгчдийг найдвартай эрчим хүчээр хангах төсөл хэрэгжүүлж “Чойбалсангийн дулааны цахилгаан станцын 50МВт-ын өргөтгөл”-ийн төсөлд 226.6 сая юанийн санхүүжилт олгоод байна.

Хөгжлийн банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг авч үзвэл өөрийн хөрөнгийн хүрэлцээ 9.0 хувиас багагүй байхаас 15.9 хувь, гадаад валютын нээлттэй позицийн харьцаа ± 30 хувийн хооронд байхаас -1.5 хувь, тогтвортой санхүүжилтийн харьцаа 100 хувиас багагүй байхаас 107.5 хувь байна.

Хүснэгт 8. МУХБ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	Байвал зохих хэмжээ	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024.1
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	>9.0%	17.8%	1.3%	13.8%	16.4%	15.9%
Гадаад валютын нээлттэй позиц	<±30.0%	8.3%	-870.9%	14.3%	27.2%	-1.5%
Тогтвортой санхүүжилтийн харьцаа	>100.0%	137.3%	168.3%	37.8%	73.1%	107.5%

Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн Банк

Монгол Улсын Хөгжлийн банк нь 2022 оны нэгдүгээр сараас эхлэн Засгийн газрын дэмжлэгтэйгээр зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн хэвлэл мэдээлэл, олон нийт, хууль, шүүхийн байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд 2022 онд 1,086.3 тэрбум төгрөг, 2023 онд 537.5 тэрбум төгрөг, 2024 оны 1-р улиралд 39.0 тэрбум төгрөгийг тус тус төлүүлж, 2021 оноос хойш өссөн дүнгээр нийт 2,180.0 төгрөгийн эргэн төлөлтийг бүрдүүлэн ажилласан.


Тус хугацаанд иргэний журмаар 24 зээл шүүхэд шилжүүлж, 21 зээлийг шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн бөгөөд тэдгээр зээлүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үргэлжлэн явагдаж байна.

Эрүүгийн журмаар 42 компанийг шалгуулахаар АТГ-т гомдол гаргаж, АТГ-аас эхний 20 зээлийн хувийн хэрэгт холбогдох хянан шалгах ажиллагааг багцлан прокурорт шилжүүлсэн. Нийслэлийн прокуророос хэргийг хянаж (84 ялалдагчтай, 80 иргэн, 4 ААН) шүүхэд шилжүүлснээр эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр гарсан.

Хүснэгт 9. МУХБ, Зээлийн эргэн төлөлт, өссөн дүнгээр



Хүснэгт 10. МУХБ, Эх үүсвэр төлөлт, өссөн дүнгээр



Эх сурвалж: Монгол Улсын Хөгжлийн банк

Хөгжлийн банк 2023 онд хугацаа нь дууссан 500.0 сая ам.долларын “Евро” бонд болон Япон улсын зах зээлд хаалттай хэлбэрээр арилжаалсан 30.0 тэрбум иений “Самурай” бондуудын эргэн төлөлтөд эх үүсвэрийг татан

төвлөрүүлж, мөн зээлийн эргэн төлөлтүүдийг эрчимжүүлэх зэргээр шаардлагатай хөрөнгийг бүрдүүлж, бондуудын төлбөрийг хугацаанд нь төлж олон улсын хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн ажилласан.

зээлжих зэрэглэл

2023



Банк нь зээлжих зэрэглэл тогтоогч Standard and Poors, Moody's, болон Fitch агентлагуудаар зээлжих зэрэглэл тогтоолгож,

Банкны зээлжих зэрэглэлийг Монгол улсын зээлжих зэрэглэлтэй ижил түвшинд хэвээр хадгалсан. Мөн Moody's агентлаг Банкны зээлийн суурь үнэлгээг САА2 түвшнээс САА1 болгон нэмэгдүүлээд байна.

1.3. ТӨСВИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын хүндрэлээс шалтгаалж эдийн засгийн өсөлт саарсан 2020-2021 онуудад төсвийг тэлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, иргэд аж ахуйн нэгжүүдийн хэрэглээний зардлыг төрөөс хариуцах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Харин 2022 оноос эхлэн эдийн засгийн өсөлт хурдсаж байгаатай холбогдуулан инфляцын өсөлтийг сааруулах болон төсвийн тэнцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж, 2023 онд төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримталсан. Бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэхэд чиглэн, ашигт малтмал дагасан далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах замаар төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Мөн Засгийн газраас нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүссэн бэрхшээлийг арилгаж, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг уул уурхайн биржээр нээлттэй, ил тод арилжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулдаг болсны үр дүнд нүүрсний экспорт 69.6 сая тоннд хүрч, улмаар эдийн засгийн өсөлт урьдчилсан байдлаар 7.0 хувь, экспортын хэмжээ 15.2 тэрбум ам.долларт хүрлээ. Ингэснээр урьдчилсан гүйцэтгэлээр 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого 24.3 их наяд төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 1.3 их наяд төгрөгөөр давж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн

тэнцэл түүхэндээ хамгийн өндөр буюу 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Ийнхүү эдийн засаг сэргэснээр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн зорилтод хүрэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд 2024 оны төсвийн бодлогыг чиглүүлсэн. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорьж байна.

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСӨВ: Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтаас сэргийлсэн хорио цээрийн дэглэмийн улмаас 2020 онд эдийн засаг огцом хумигдаж, Засгийн газар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх бодлогын арга хэмжээнүүдийг шат дараалан хэрэгжүүлсэн.

Ингэснээр Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 12,711.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 29.2 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 15,630.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.9 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2,919.0 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 6.7 хувьтай гарсан.

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСӨВ: Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд авч хэрэгжүүлсэн вакцинжуулалтын үр нөлөөгөөр бизнесийн үйл ажиллагааг бүрэн нээж эдийн засгийг сэргээх, гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын томоохон төслүүдийг эхлүүлэх, эдийн засгийг тэлэх, “Хөдөлмөр, бүтээмж, өсөлт”-ийг дэмжих төсвийн бодлого, зарчмыг баримталж, “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилт 2030, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийг батлуулсан.

Ингэснээр Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого 17,126.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.8 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлага 18,159.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, төсвийн нийт тэнцэл 1,032.7 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1.9 хувьтай тэнцсэн.

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСӨВ: Цар тахлын болон геополитикийн хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримталсан. Монгол Улсын 2023 оны төсвийн бодлогоор төрийн хэмнэлтийг хэрэгжүүлж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн багц арга хэмжээнд чиглүүлсэн.

Монгол Улсын төсвийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 23,217.9 тэрбум төгрөг, нийт зарлага 22,454.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарч ДНБ-ий 1.1 хувьтай тэнцэхээр байна.

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСӨВ: Монгол Улс 2024 оны төсвийн бодлогоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Ингэснээр Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 25,855.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.9 хувь, нийт зарлага 27,360.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.0 хувь, төсвийн алдагдлын хэмжээ хуульд заасан хязгаар буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар хуульчлагдан батлагдсан.

1.3.1 Төсвийн ил тод байдлын үнэлгээ

Засгийн газраас төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлж, төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлж ирлээ. Үүний үр дүнд олон улсад Монгол Улсын ил тод байдлын үнэлгээ 2017 онд 46, 2019 онд 56, 2021 онд 60 хүрч сайжирч 120 улсаас 38 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Тус үнэлгээг "International Budget Partnership" байгууллагаас 2 жил тутам оролцогч улс бүрийн төсвийн найман үндсэн баримт бичгийн цахим хэлбэрээр нээлттэй, цаг хугацаандаа нийтлэгдсэн, иж бүрэн байдал зэргийг харгалзан 109 шалгуур үзүүлэлтээр үнэлж, улс бүрийг 0-ээс 100 хүртэлх оноогоор үнэлдэг.

Ил тод байдлыг сайжруулахын зэрэгцээ иргэдийн төсвийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх энгийн мэдлэгээс эхлээд Монгол Улсын төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын үйл явцад хэрхэн оролцож болох тухай мэдээллийг хүргэж ирлээ. Үүний нэг нь “Ирээдүйгээ төсөвлө” аян бөгөөд тус аянаар төсвийн талаарх цуврал видео контент, нийтлэлүүд, эссе бичлэг, эрдэм шинжилгээний хурал, дата хакатон, залуу мэргэжилтэн, судлаачдад зориулсан менторшип хөтөлбөрийг тус тус зохион байгуулсан.

График 23. Монгол улсын төсвийн ил тод байдлын үнэлгээ



Эх сурвалж: International Budget Partnership


1.3.2 Төсвийн гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2020 онд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас шалтгаалан 9,463.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 13.2 хувиар буурсан бол 2021 онд 12,711.4 тэрбум төгрөгт хүрч 34.3 хувиар, 2022 онд 17,126.9 тэрбум төгрөгт хүрч 34.7 хувиар, 2023 онд 23,217.9 тэрбум төгрөгт хүрч 35.6 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсын төсвийн нийт зарлага нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг бууруулахгүй байх, хүн амын өсөлт, үнэ ханшийн өөрчлөлт, нийгмийн үйлчилгээний салбарт хийгдсэн бодлогын арга хэмжээний нөлөөлөл болон шинэ хөрөнгө оруулалтын ашиглалт, УИХ-аас шинээр баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй

холбогдуулан орон тоо, урсгал зардлыг тухай бүрд нь төсөвт тусган, хэвийн үйл ажиллагааг ханган санхүүжүүлсэн ба 2020 онд 13,904.3 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 22,454.5 тэрбум төгрөгт хүрч өссөн байна.

График 24. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

График 25. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, тэрбум төгрөг





График 26. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2020 онд 4,440.4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 11.9 хувьтай тэнцэж байсан бол 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 763.4 тэрбум төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 1.1 орчим хувьтай тэнцэж байна.

1.3.3 Төсвийн орлогод баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт

1/ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг олон улсын зах зээлийн үнэд үндэслэн тооцох зохицуулалтыг хийсэн:

Татварын тэгш шударга зарчмыг хангах, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 174 дүгээр тогтоолыг баталж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн борлуулалтын үнэлгээг олон улсын зах зээлийн үнэд үндэслэн тооцохоор болсон.

2/ “Боомтын сэргэлт”-ийн ажлыг эрчимжүүлж, экспортоос орох төсвийн орлогыг нэмэгдүүлсэн:

Боомтын сэргэлтийн ажлыг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлснээр цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүргэхээр зорьж байсан. Боомтын сэргэлтийн хүрээнд экспортын боомтуудыг автозам болон төмөр замаар холбох, экспортын шинэ гарц нээх, хилийн боомтуудын дэд бүтцийг сайжруулах, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн болно. Үүний үр дүнд нүүрсний экспортын хэмжээ 2023 онд 69.6 сая тоннд хүрч түүхэн дээд амжилтыг шинэчлэн тогтоосон.

3/ Татварын бүртгэлийг сайжруулан, далд эдийн засгийг бууруулах, татварын суурийг өргөжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

Гааль, татвар, санхүүгийн бүртгэл, мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, бараа бүртгэлийн нэгдсэн систем, төлбөрийн баримтын бүртгэлийг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд цахим төлбөрийн хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлж, төвлөрсөн зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа болон төлбөрийн баримт олголтын түвшин багатай иргэд, аж

ахуйн нэгжүүдийн ажил гүйлгээг бүртгэх, төлбөрийн баримт олгох ажлыг эрчимжүүлсэн болно.

4/ Уул уурхайн төсөл хөтөлбөрөөс орон нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлсэн: Орон нутагт уул уурхайн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжиж, уул уурхайн төсөл хөтөлбөрөөс нутгийн иргэдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах эрх зүйн зохицуулалт хийсэн. Энэ хүрээнд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг холбогдох орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх заалтыг Төсвийн тухай хуульд нэмж тусгасан.

5/ Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр ашигт малтмалыг нээлттэй, ил тод, олон улсын зах зээлийн үнээр борлуулах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг биржийн үнэд үндэслэн тооцохоор болсон: Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр дамжуулан арилжаанд оролцох аж ахуйн нэгжүүдийг нэмэгдүүлэх, ил тод, нээлттэй арилжааг дэмжих хөшүүрэг бий болгох үүднээс Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 345 дугаар тогтоолоор биржээр дамжуулан борлуулсан ашигт малтмалын бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг биржийн үнэд үндэслэн тооцох нөхцөлийг бүрдүүлсэн.

1.3.4 Татварын бодлогын шинэчлэл, түүний үр дүнгийн тухай

Албан татварын тухай хууль 1990 онд батлагдсанаар Монгол Улсын шинэ үеийн татварын тогтолцооны суурь тавигдсан бөгөөд одоогийн байдлаар Монгол Улсад 30 гаруй төрлийн татварыг ногдуулж нэгдсэн төсвийн нийт орлогын 85 орчим хувийг бүрдүүлж байна.

Татварын ерөнхий хууль болон тусгайлсан татварын хууль, тогтоомжийн дагуу дараах албан татвар нь төсвийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/
- Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/
- Гаалийн албан татвар /ГАТ/
- Онцгой албан татвар /ОАТ/

Монгол Улс нь татварын хувь, хэмжээгээр дунджаас доогуур улсад тооцогдож байна. Тухайлбал, Дэлхийн банкны “DOING BUSINESS” судалгаагаар Монгол Улс нь 211 орноос 178 дахь бага татвартай улсад багтаж байна.

Өнгөрсөн оны байдлаар Монгол Улсад бүртгэлтэй 158,215 аж ахуйн нэгж орлогын албан татварын тайлан тушаасан бөгөөд нийт 138.4 их наяд төгрөгийн борлуулалт хийж, нийт 9,332.9 тэрбум төгрөгийн албан татварыг төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс томоохон буюу 20 тэрбум төгрөгөөс дээш борлуулалттай 763 аж ахуйн нэгж нь нийт татварын орлогын 71.4 хувийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн Газраас бизнесийн орчныг сайжруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, татварын үйл ажиллагааг цахимжуулж хялбаршуулах, татвараас зугтах, зайлсхийх явдлын эсрэг тэмцэх зорилгоор татварын шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Татварын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд Татварын ерөнхий хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай шинэ хуулиудыг 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр УИХ-аар батлуулсан нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. Улмаар, жил бүрийн төсвийн тухай хуулийг дагалдуулан хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр холбогдох татварын хуулиудад олон өөрчлөлтийг тусгасан болно. Татварын хууль тогтоомжид орсон томоохон өөрчлөлтүүдийг дурдвал:

ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД:

1/ Хялбаршуулсан татварын горимыг нэвтрүүлсэн: Жилийн 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлого бүхий бичил бизнес эрхлэгч хувь хүний бизнесийн үйл ажиллагааны орлогод ногдуулах албан татварыг 1% болгон бууруулж, хялбаршуулсан горимоор орлогын албан татвар тайлагнах боломжийг олгосон.

2/ Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ачааллыг 1% болгон бууруулсан: Жилд 300 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны орлогод ногдуулах албан татвар 1%, Жилд 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд 10 хувиар татвар төлж дараа жил нь төлсөн татварын 90 хувийг буцаан авах юм.

3/ Татвар төлөгчийн татварын тайлан гаргах цаг зардлыг бууруулж, татварын тайлан гаргах давтамжийг бууруулсан: Жилд 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд жилд 4 удаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан хүргүүлдэг байсныг бууруулж 2 болгосон.

4/ Алслагдсан аймаг сумдад үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт эдлүүлнэ: Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд үйл ажиллагаа эрхэлсэн бол төлөх татварыг 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар тус тус хөнгөлнө.

5/ Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжсэн татварын дэмжлэгүүд:

- ААНОАТ-ын алдагдал шилжүүлэх хугацааг 2 жил байсныг 4 жил болгон нэмэгдүүлсэн.
- Татварын өр төлөг хугацаанд хөнгөлөлт үзүүлж 2 сар байсныг 2 жил болгон нэмэгдүүлсэн;
- ААНОАТ-аас хасагдах зардлыг зөвхөн хуульд заасан зардлыг хамруулдаг байсныг уян хатан болгож шаардлага хангасан бүх төрлийн зардлыг хасагдуулах боломжийг бүрдүүлсэн.
- Албан татварын тайланг 1 жилийн хугацаанд залруулах боломжийг бүрдүүлсэн.

6/ Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх татварын дэмжлэгүүд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зорилгоор үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах хугацааг 40 жил байсныг 25 жил болгож бууруулсан /уул уурхайн салбар хамрахгүй/.
- Дотоодын аж ахуйн нэгжийн дотоод, гадаадын анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл худалдан авсан хөрөнгө оруулагчийн хүүгийн орлогод 10 эсхүл 20 хувиар татвар ногдуулж байсныг 5 хувь болгон бууруулсан /уул уурхайн салбар хамрахгүй/.
- Арилжааны банкны гадаад, дотоодын эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн зээл, өрийн хэрэгсэл /бонд/-ын хүүгийн татварыг 10 хувь байсныг 5 хувь болгон бууруулсан.

7/ Бусад татварын дэмжлэгүүд:

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал, модны суулгац үйлдвэрлэсэн болон тариалсан бизнес эрхлэгчдийн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах орлогын албан татварыг 50 хувиар хөнгөлнө.
- Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг;

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТАТВАРЫН БОДЛОГО:

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдлыг дэмжиж төвлөрлийг сааруулах зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн татварын дэмжлэгүүд. Үүнд:

- 2023 оноос хойш хэрэгжих дулаан, цахилгааны төслүүдийг борлуулалт хийж эхэлснээс хойш гурван жил 90 хувь, дараагийн гурван жил 50 хувиар тус тус орлогын татвараас хөнгөлөх;
- Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж үйлдвэр, агуулахаа орон нутагт нүүлгэсэн

тохиолдолд нүүлгэн, шилжүүлэлтийн зардлыг 50 хувиар нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасах (үүнд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хамаарахгүй);

- 3/ Орон нутагт барьж байгуулсан барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацаа одоо 25 жил байгааг өөрийн сонголтоор 15 жилийн дотор түргэн хугацаанд элэгдүүлэн тооцож зардлаа хурдан нөхөх (үүнд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хамаарахгүй);
- 4/ Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж тухайн орон нутгаас ажил хайгч иргэнийг ажилд авсан тохиолдолд тухайн аж ахуйн нэгж тухай иргэнд олгосон цалингийн зардлыг 20 хувиар нэмэгдүүлэн татвар ногдох орлогоос хасаж тооцох зэрэг болно.

МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ 2023 ОНЫ ТӨСВИЙН ТАТВАРЫН БОДЛОГО:

Үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлсэн:

- Үнэт цаасны зах зээлд нээлттэй арилжаалагдах ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй компанийн хувьцааны ногдол ашгийн суутган татварыг 5 хувь болгох;
- Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх;
- Хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгохтой холбоотой зардлыг 20 хувиар өсгөж тооцон татварын хөнгөлөлт үзүүлэх;

Гарааны бизнес, мэдээллийн технологи (IT)-ийн компаниудыг дэмжсэн:

- Инновацийн тухай хуульд заасан гарааны компанийн дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогод ногдох албан татварыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд бүрэн хөнгөлөлт үзүүлэх;
- Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн эрхийн шимтгэл, сервер түрээслэх төлбөрийг Монгол Улсад байрладаггүй этгээдэд шилжүүлсэн орлогод ногдуулах албан татварын хувь хэмжээг 5 хувь болгож бууруулах;

Түгжрэлийг бууруулахад хувь нэмрээ оруулсан аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн:

Ажилтандаа нийслэл хот дотор нийтийн тээврээр зорчих тасалбар, эрхийг олгосон аж ахуйн нэгжүүдэд холбогдон гарсан зардлыг 50 хувиар нэмэгдүүлж аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасаж тооцох;

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн: Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 он хүртэл 100 хувь хөнгөлөх зэрэг болно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд үзүүлдэг хөнгөлөлт, чөлөөлөлт. Үүнд:

- Хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн, боловсрол, эрүүл мэнд зэрэг зайлшгүй хэрэгцээний мах, сүү, хүнсний ногоо, жимс зэрэг 28 төрлийн бараа, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийтийн хэрэгцээний 19 төрлийн үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг.
- Гаалийн байгууллагад мэдүүлж, экспортод гаргасан бараанд НӨАТ-ын “0” хувь ногдуулдаг.

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТАТВАРЫН БОДЛОГО:

Хувиараа бизнес эрхлэгчдийн татварын орчныг хялбаршуулж, хамрагдалтыг сайжруулах чиглэлээр: Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн татварын орчныг энгийн, ойлгомжтой болгон хялбаршуулж бизнесийн орчныг сайжруулах зорилгоор орлогын хэмжээ үл хамаарч 1 хувийн татварын хялбаршуулсан горимд хамрагдах боломжийг нээх;

Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг дэмжих чиглэлээр:

- Гадаадын хөрөнгө оруулагчид дотоодын хөрөнгө оруулагчидтай ижил нөхцөлөөр буюу Монголын үнэт цаасны зах зээлээс худалдан авсан үнэт цаасаа борлуулахад анх худалдаж авсан дүн болон шимтгэлийн зардлаа хасаж, ашгаас татвараа тооцох;
- Хөрөнгийн бирж дээрх үнэт цаасны арилжааг дэмжих зорилгоор үнэт цаас борлуулсны орлогод 2029 он хүртэл 90 хүртэлх хувийн татварын хөнгөлөлт үзүүлэх;
- Хөрөнгийн биржийн арилжаанд оролцогчид тус бүр татвараа өөрөө тооцож тайлагнадаг байх тогтолцоог өөрчилж төр өөрт байгаа арилжааны мэдээлэлд үндэслэн татвар төлөгчдөд хүндрэлгүй нэгдсэн журмаар татварыг суутган тооцох системийг нэвтрүүлэх зэрэг болно.

Малчдын татварын орчныг хялбаршуулах, малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулах, боловсруулах үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр: Малын гаралтай түүхий эдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, цаашид малчдаас авах татварын тайлагналтыг хялбаршуулж, төр өөрт байгаа мэдээллээр татварын тооцоолол гаргадаг болох өөрчлөлтийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс нэвтрүүлсэн.

1.3.5 Төсвийн урсгал зарлагад баримталсан бодлого, хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, арга хэмжээ, бодлогын өөрчлөлт болон авч хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэмжээ

Нэгдсэн төсвийн урсгал зарлагад 2020-2024 онд баримталсан бодлого нь дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн эрүүл мэнд,

ажлын байр, орлогыг хамгаалах багц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх, ОХУ-Украины хямралт нөхцөл байдал болон БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлсэн “Тэг Ковид” бодлогын нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэх, эдийн засагт үүссэн эмзэг байдлыг бууруулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Мөн эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэхэд чиглэн, ашигт малтмал дагасан далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлсэн.

Төсвийн урсгал зардлын өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 2021 онд 21 хувь, 2022 онд 3 хувь, 2023 болон 2024 онд дунджаар 25 хувь байна. Төсвийн урсгал зардлын өсөлт 2022 онд эрс буурахад Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж бүх шатны байгууллагуудыг хэмнэлтийн горимд ажиллуулах, хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлэхгүй байх, цомхон, чадварлаг хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хэдийгээр 2021-2024 оны төсвийн жилүүдэд зарлагын өсөлтийг хязгаарлах бодлого баримталсан хэдий ч хүн амын өсөлт, үнэ ханшийн өөрчлөлт, нийгмийн үйлчилгээний салбарт хийгдсэн бодлогын арга хэмжээний нөлөөлөл болон шинэ хөрөнгө оруулалтын ашиглалт, УИХ-аас шинээр баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан орон тоо, урсгал зардлыг тухай бүрд нь төсөвт тусган, хэвийн үйл ажиллагааг ханган санхүүжүүлж ирсэн байна.

Түүнчлэн 2021-2024 онд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан дараах онцлог томоохон хөтөлбөр арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1/ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд зориулж 2020-2022 онд 11,201.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулсан байна. 2020-2022 онд төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийн 37.9 хувийг эдийн засгийг идэвхжүүлэхэд, 12.5 хувийг ажлын байрыг хамгаалахад, 13.2 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад, 36.4 хувийг иргэдийн орлогыг хамгаалахад тус тус зарцуулсан байна. Төсвийн зарцуулалтыг он оноор нь харуулбал:

- 2020 онд нийт 4,402.1 тэрбум төгрөг зарцуулснаас 1,192.8 тэрбум төгрөгийг ажлын байрыг хадгалах, 1,082.8 тэрбум төгрөгийг иргэдийн орлогыг хамгаалах, 373.1 тэрбум төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, 1,753.4 тэрбум төгрөгийг эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээнд;
- 2021 онд нийт 5,164.9 тэрбум төгрөг зарцуулснаас 209.2 тэрбум төгрөгийг ажлын байрыг хадгалах, 1,672.8 тэрбум төгрөгийг иргэдийн орлогыг

хамгаалах, 792.6 тэрбум төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, 2,490.3 тэрбум төгрөгийг эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээнд;

- 2022 онд нийт 1,634.7 тэрбум төгрөгийн зардал гарсны 311.8 тэрбум төгрөгийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, 1,322.9 тэрбум төгрөгийг иргэдийн орлогыг хамгаалах арга хэмжээнд тус тус зориулж санхүүжүүлсэн.


2/ Эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлж төрийн үйлчилгээний албан хаагчийн цалинг нэг шатлал бүхий суурь цалинтай болгох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, мэргэжлийн боловсрол, шинжлэх ухаан, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг нэг шатлал бүхий суурь цалинтай болгоход 2022 онд нийт 34.0 тэрбум төгрөг төсөвлөсөн. Төрийн албан хаагчдын цалинг нэг шатлал бүхий суурь цалинтай болгох арга хэмжээг үргэлжлүүлж 2023 онд төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэг суурьтай болгоход 266.2 тэрбум төгрөг төсөвлөсөн. Цалин хөлсний шинэчлэлийн бодлого хэрэгжүүлж 2023 оны төсвийн тодотголоор 994.2 тэрбум төгрөг төсөвт тусгасан. Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлж 2024 оны 04 сарын 01-ээс төрийн тусгай болон захиргааны албан хаагчдын цалинг 10 хувь нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 20 хувь нэмэгдүүлэхээр төсөвт 889.8 тэрбум төгрөг тусгасан.

3/ Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийн шинэчлэлээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг санхүүгийн эргэлтэд оруулах, ахмадын орлогыг хамгаалах зорилгоор тэтгэврийг дундаж цалингийн өөрчлөлт, инфляцын түвшинтэй уялдан жил бүр тогтмол нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүү арилгах итгэлцүүр хэрэглэх, даатгуулагчдад үзүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн хүртээмжийг сайжруулах, залуу малчдыг дэмжиж нийгмийн даатгалын сангийн өгөөжийг нэмэгдүүлэх бодлогыг тодорхойлсон.

4/ Уул уурхайн орлогын тодорхой хувиас бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал санаачилга дээр тулгуурлан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн Орон нутгийн хөгжлийн сангийн жил бүрийн шилжүүлгийн хэмжээг нэмэгдүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангаас 2020 оны төсвийн жилд 165.6 тэрбум төгрөг, 2021 онд 232.6 тэрбум төгрөг, 2022 онд 231.5 тэрбум төгрөг, 2023 онд 362.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 482.1 тэрбум төгрөг байхаар батлагдсан.

График 27. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, тэрбум төгрөг



5/ Агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх ажлын хүрээнд 2021-2024 онуудад орон нутгийн төсөвт нийт 218.2 тэрбум төгрөгийг батлуулсан байна. Мөн Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онуудад нийт 170.0 тэрбум төгрөгийг батлуулсан.

6/ Хөдөө аж ахуйн салбарт ноос, арьс шир, ноолуур, мах, сүү, улаанбуудай, хүнсний ногооны урамшуулалд 2021-2024 онуудад нийт 278.1 тэрбум төгрөг төсөвлөн олгосон байна. Тус хугацаанд ноосны урамшуулал нийт 99.9 тэрбум төгрөг, арьс, ширний урамшуулалд нийт 31.4 тэрбум төгрөг, ноолуурын зээлийн хүүгийн хөнгөлөлтөд нийт 2.3 тэрбум төгрөг (2021 он), нөөцийн махны урамшуулалд нийт 27.2 тэрбум төгрөг, сүүний урамшуулалд 22.6 тэрбум төгрөг, улаанбуудайн урамшуулалд нийт 78.6 тэрбум төгрөг, хүнсний ногооны урамшуулалд нийт 16.1 тэрбум төгрөг тус тус батлуулсан.

7/ Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, политехник коллежид суралцагчдад олгох тэтгэлгийг хэмжээг суралцагчид сар тутам 200.0 мянган төгрөгөөр тооцоолж олгосон. Энэ хүрээнд 2021-2024 онд төсөвт 205.7 тэрбум төгрөг батлагдсан.

8/ Боловсролын сургалтын байгууллагуудад гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлсэн. Энэ хүрээнд 2023-2024 онд төсөвт 149.6 тэрбум төгрөг батлагдсан.

9/ Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2023 онд урсгал зардалд 86.8 тэрбум төгрөг, 2024 онд 96.6 тэрбум төгрөг тус тус баталсан байна.

10/ Монгол Улсын Их Хурлаас Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг 2020 оны 01

дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр баталсан. Энэ хугацаанд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 34.4 мянган иргэн нийгмийн даатгалын шимтгэлд 76.4 тэрбум төгрөг төлсөн. Эдгээр иргэдээс 2023 оны байдлаар 20.6 мянган иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна.

11/ Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд улсын төсвөөс 2024 онд нийт 9.0 тэрбум төгрөг төсөвлөн батлуулсан. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжлийг дэмжих зорилгоор 2022-2024 онуудад нийт 59.4 тэрбум төгрөг төсөвлөн батлуулсан.

12/ Хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцаж байгаа болон сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад 100 хувь хүртэл сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох “Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр” хэрэгжүүлж, энэ хүрээнд 2021-2024 онд төсөвт нийт 23.9 тэрбум төгрөг батлагдсан.

13/ Иргэдийн албан боловсролоос гадна өөрийн хэрэгцээ, сонирхол, боломж, нөхцөлдөө нийцүүлэн мэргэжил, боловсрол, мэдлэг, чадвараа тасралтгүй хөгжүүлэх, бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх хүрээнд 2021-2024 онд төсөвт 23.9 тэрбум төгрөг батлагдсан.

14/ Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны зардлыг 60 хувь, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах суралцагчийн хоногийн хоолны зардлыг дунджаар 30 хувиар тус тус инфляц, үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн.

15/ Эрх зүйн салбарт хийсэн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбогдуулан шинэчилсэн найруулгаар батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байна.

1.3.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 2020 онд 1,654.3 тэрбум төгрөг, 2021 онд 1,685.2 тэрбум төгрөг, 2022 онд 1,697.4 тэрбум төгрөг, 2023 онд 2,965.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан. Дөрвөн жилийн хугацаанд нийт 8,002.5 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ батлагдан хэрэгжсэнээс нийт 7,389.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан нь Монгол улсын

түүхэнд 4 жилийн хугацаанд хийгдсэн хамгийн өндөр үзүүлэлт юм. 2020-2023 оны бүтээн байгуулалтын хувьд:



155 цэцэрлэг



102 сургууль



63 эмнэлэг




58 соёлын барилга



**505.1 км хатуу
хучилттай авто зам**

Харин 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 3,359.4 тэрбум төгрөгийн 1,299 төсөл, арга хэмжээ, концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 1 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 25.0 тэрбум төгрөг, нийт 3,384.4 тэрбум төгрөгийн 1300 төсөл, арга хэмжээ батлагдсан. Төсвийн хөрөнгө оруулалтыг барилга байгууламжийн төрлөөр доорх графикт харуулав.

График 28. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам


МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ

ОРУУЛАЛТ: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сонгохдоо дараах бодлого, зарчмыг баримталлаа. Үүнд:

- Он дамжин хэрэгжих шилжих төслүүдийг санхүүжилтийг хуулийн дагуу 2020 онд бүрэн санхүүжүүлэх;
- Царцаагдсан төслүүдийг дуусгахад шаардлагатай санхүүжилтийг тусгаж, олон жил үргэлжилсэн төслүүдийг бүрэн дуусгах;
- Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалтын нэмэгдүүлж, ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэх;
- Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлэх;
- COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх;
- Дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг дэмжих;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад эхлүүлсэн 503 төслийн үлдэгдэлд 778.6 тэрбум төгрөг, Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр 2015-2017 онд гэрээ байгуулсан 9 төслийн эргэн төлөлтөд 323.6 тэрбум төгрөг, 2020 онд шинээр эхлүүлэх 844 төсөлд 552.3 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож, <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглалтад орууллаа.



САНГИЙН ЯАМ

Та QR кодыг уншуулан апп татаж аваарай

"Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем"

PIMIS 3.0 хувилбарыг нэвтрүүлээ.

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг 21 аймаг, нийслэл, яамдууд цахимаар төлөвлөдөг боллоо.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт илүү ил тод, нээлттэй боллоо.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэгч компани санхүүжилтаа авахын тулд олон үе шатаар дамжиж, их хэмжээний цаасан материал бүрдүүлдэг байдлыг арилгаж, санхүүжилтийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг болж байна.
- ✓ Иргэд, олон нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төслүүдийг хаана хэрэгжиж байгаа, ямар компани гүйцэтгэж байгаа, санхүүжилт авсан эсэх зэрэг бүхий л мэдээллийг хүссэн цагтаа авч чаддаг боллоо.
- ✓ Мэдээллийн урсгалыг нэг болгох, шаардлагатай мэдээллүүдийг хэрэгжиж байгаа системээс цаг тухай бүр авдаг байх, хэрэглэгчдэд хялбар байлгах үүднээс одоогийн байдлаар үндэсний 8 цахим системтэй холбогдож ажилладаг боллоо.

www.publicinvestment.gov.mn

#ЦааснаасЦахимд

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад эхлүүлсэн 643 төслийн үлдэгдэлд 940.6 тэрбум төгрөг, Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг, 2021 онд шинээр эхлүүлсэн 458 төсөлд 478.3 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Үүнээс онцлох бүтээн байгуулалтуудыг дурдвал:

- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмжид 110.0 тэрбум төгрөг;
- Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгөд 64.0 тэрбум төгрөг;
- Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалтад 50.5 тэрбум төгрөг;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвт 31.9 тэрбум төгрөг;
- Шинжлэх ухаан, инновацын төвийн кластерт 24.0 тэрбум төгрөг;
- Чингис хаан музейн барилгад 22.0 тэрбум төгрөг.

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дунд хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг тогтвортой түвшинд хадгалж, эдийн засгийн идэвхжилийг үргэлжлүүлэн дэмжих зарчим баримталж, төслүүдийг хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулах бодлогыг хэрэгжүүлж, Засгийн газрын үйл

ажиллагааны хөтөлбөр, 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хангах зорилгоор дараах чиглэл, зарчмыг баримталсан. Үүнд:

- Боловсрол, эрүүл мэндийн салбарыг үргэлжлүүлэн дэмжиж, төвлөрлийг сааруулах төслүүдийг хэрэгжүүлэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн төслүүдийг төлөвлөсөн байх;
- Батлагдсан зураг төсөвтэй, газрын асуудал шийдэгдсэн байх;
- Төсвийн хөрөнгө оруулалтыг тэгш хуваарилах бус тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэх.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад эхлүүлсэн 705 төслийн үлдэгдэлд 795.3 тэрбум төгрөг, Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 7 төслийн эргэн төлөлтөд 303.6 тэрбум төгрөг, 2022 онд шинээр эхлүүлсэн 664 төсөлд 598.4 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийг бий болгож, нийгмийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад түлхүү чиглэж ирсэн, энэ хүрээндээ 2023 онд дараах бодлого, зарчим, эрэмбийг баримтлан ажиллаж, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийлээ. Үүнд:

- Хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр эрэмбэлсний үндсэн дээр тусгах;
- Төсвийн ачааллыг бууруулах зорилгоор өндөр төсөвт өртөгтэй, томоохон төслүүдийг төслийн баримт бичигт үндэслэн үе шаттай, хэсэгчлэн хэрэгжүүлэх;
- Ирэх онуудад төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллах;
- Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий шинэ төслүүдийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл”-ээр хэрэгжүүлэхээр төлөвлөх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих.

Монгол Улсын Засгийн газраас Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд жил бүр 420-оос доошгүй тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгаж, санхүүжүүлж байхаар 2021 онд шийдвэрлэсний дагуу 2023 оны төсвийн төсөлд нийт 339.7 тэрбум төгрөгийг тусгасан бөгөөд Засгийн газрын 2022 оны 06 сарын 08-ны өдрийн 226 дугаар

тогтоолоор батлагдсан 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний 57.3 хувь нь орон нутагт, 29.2 хувь нь нийслэлд, 13.5% нь улсын хэмжээнд хэрэгжих төслүүд байгаа бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 32.8 хувь нь нийгмийн хөгжлийг дэмжих боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт, 62.8 хувь нь эдийн засгийн хөгжлийг дэмжих авто зам, эрчим хүч, инженерийн шугам сүлжээний салбарт хэрэгжих бол төрийн захиргаа 1.3 хувь болон аюулгүй байдал ба гадаад харилцааны салбарт 3.1 хувь тус тус хэрэгжихээр байна.

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: Төсөл арга хэмжээг сонгохдоо дараах бодлого, зарчмыг баримталсан. Үүнд:

- Хот хөдөөгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн бодлогыг дэмжихэд төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх;
- Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэх;
- Хөдөөгийн алслагдсан багуудаас мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй багуудыг харилцаа, холбоожуулах;
- Иргэдийн оролцоонд суурилсан ил тод, цахим, хэмнэлттэй бөгөөд үр ашигтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг дэмжих;
- Олон жил үргэлжилсэн дуусаагүй барилга байгууламжийг ашиглалтад оруулах;
- Төсөвт өртгийн нэмэгдлийг аудитын дүгнэлтэд үндэслэн төсвийн төсөлд тусгах;

Төсвийн Ерөнхийлөн захирагчдаас шилжих буюу он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний 2.8 их наяд төгрөгийн санал ирүүлснээс 946.5 тэрбум төгрөг нь төсөвт өртгийн нэмэгдэл санхүүжилт бөгөөд эдгээрийг УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоолын дагуу аудитын дүгнэлт гаргуулахаар Үндэсний аудитын газарт хүргүүлснээс баталгаажуулж ирүүлсэн 214 төслийн 560.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн нэмэгдлийг бүрэн тусгалаа.

Шинэ хөрөнгө оруулалтын хувьд Төсвийн ерөнхийлөн захирагчдаас нийтдээ 11.0 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтын санал ирсэн бөгөөд үүнийг холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, цахим систем, аргачлалын шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх, мөн зураг төсөв, газрын асуудал бүрэн шийдэгдсэн байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр эрэмбэллээ.

Түүнчлэн, Шинэ сэргэлтийн бодлогын “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийг дэмжих

зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг нийтдээ 21 аймагт ажилласнаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, тухайн орон нутагт нэн тэргүүний болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төсөл, арга хэмжээг 7800 гаруй иргэдэд танилцуулж, иргэдийн саналыг авсны үндсэн дээр төслийн бэлэн байдлаар эрэмбэлэн төсвийн төсөлд тусгалаа.

1.3.7 Гадаад зээл, тусламжаар санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, хэрэгжүүлсэн арга хэмжээ, баримталсан зарчим, түүний үр дүнгийн тухай

ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ: Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2023 онд авч ашиглах зээл, тусламжийн төслийн төсвийг төлөвлөхдөө эдийн засгийн өсөлтийг дэмжих, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслүүдийг тэргүүн ээлжид санхүүжүүлэх, мөн коронавируст цар тахал (КОВИД-19)-аас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн эсрэг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүд, хэрэгжиж дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгах, үргэлжилж буй төслүүдийн хувьд гэрээ хэлэлцээрт тусгагдсан төлөвлөгөөг харгалзан гэрээний хэрэгжилтийг хангах хэмжээнд, шинэ төслүүдийн ажил эхлүүлэх хэмжээнд ашиглалтыг тусгах зарчим баримталсан болно.

Цаашид олон улсын эдийн засаг, санхүү, төсвийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийг Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглүүлэн уялдуулж, ач холбогдлоор нь эрэмбэлж, зарим шаардлагагүй төслүүдийг зогсоох, хойшлуулах зайлшгүй шаардлага урган гарсан. Ялангуяа гадаад төслийн зээлийн хувьд бодлогын өөрчлөлт хийж, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн дагуу гадаад зээл, тусламжийн төслүүдийг дахин эрэмбэлж, дараах төслүүдийг цаашид хэрэгжүүлэхгүй байх бодлогыг 2023 оны төсвийн жилээс эхлүүлсэн. Үүнд:

- Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй төслүүд;
- Гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөдөг төслүүд /зарим 2 талт төслүүд/
- Төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий төслүүд;
- Олон удаа хугацаа сунгаж, хэрэгжилт, санхүүжилт удаашралтай байгаа төслүүд;
- Шаардлагагүй томоохон зөвлөх үйлчилгээ бүхий төслүүд зэрэг болно.

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСӨВ- ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ:

2020 оны төсөвт 16 төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах гадаад зээлийн 130 төслийн 1,472.9 тэрбум төгрөг, гадаад тусламжийн 45 төслийн

150.3 тэрбум төгрөг, нийт 175 төслийн 1,623.2 тэрбум төгрөгийн төсвийг тооцон тусгаж, батлуулсан. Үүнээс зээлийн 118 төслийн 1,296.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, тусламжийн 34 төслийн 146.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, нийт 152 төслийн 1,442.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Эрх зүйн орчны хувьд онцгой байдал, гэнэтийн гамшгийн үед эх үүсвэр бүрдүүлэх Олон улсын гэрээ хэлэлцээрийг УИХ, ЗГ-аар хэлэлцүүлэх шат дарааллыг багасгаж, хялбаршуулах зорилгоор Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт заалт оруулав. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын систем /odamis.mof.gov.mn/-ийг шинэчлэн хөгжүүлж, нэвтрүүлээ.

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ТӨСӨВ- ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ:

2021 оны төсөвт 20 төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах гадаад зээлийн 137 төслийн 1,205.1 тэрбум төгрөг, гадаад тусламжийн 42 төслийн 150.3 тэрбум төгрөг, нийт 179 төслийн 1,355.4 тэрбум төгрөгийн төсвийг тооцон тусгаж, батлуулсан. Үүнээс зээлийн 93 төслийн 1,177.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, тусламжийн 30 төслийн 150.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, нийт 123 төслийн 1,341.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСӨВ- ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ: 2022 оны төсөвт 19 төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах гадаад зээлийн 122 төслийн 1,307.6 тэрбум төгрөг, гадаад тусламжийн 38 төслийн 298.5 тэрбум төгрөг, нийт 160 төслийн 1,606.1 тэрбум төгрөгийн төсвийг тооцон тусгаж, батлуулсан. Үүнээс зээлийн 78 төслийн 1,306.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, тусламжийн 28 төслийн 298.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, нийт 106 төслийн 1,548.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСӨВ- ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ:

Монгол Улсын 2023 оны төсөвт 19 төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах гадаад зээлийн 108 төслийн 1,224.5 тэрбум төгрөг, гадаад тусламжийн 32 төслийн 570.5 тэрбум төгрөг, нийт 140 төслийн 1,795.0 тэрбум төгрөгийн төсвийг тооцон тусгаж, батлуулсан. Үүнээс зээлийн 69 төслийн 1,221.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, тусламжийн 25 төслийн 310.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, нийт 94 төслийн 1,532.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСӨВ- ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ:

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголоор гадаад төслийн зээлийн ашиглалт 1,224.5 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 570.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2024 онд 1,225.0 тэрбум төгрөгийн зээл, 558.0 тэрбум төгрөгийн тусламж авч ашиглахаар төсвийн төсөлд тусгалаа.

2024 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 40.7 хувийг хөгжлийн түнш олон улсын байгууллага, 59.3 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд өмнөх жилүүдийн адил нийт зээл, тусламжийн санхүүжилтэд эзлэх Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилт өндөр хэвээр 26.3 хувийг эзэлж байгаа бол Дэлхийн банк (ДБ)-ны санхүүжилт 6.1 хувийг, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ных 6.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 11. Гадаадын зээл, тусламжийн 2024 оны төлөвлөгөө, хөгжлийн түншээр, тэрбум төгрөг

Хөгжлийн түншүүд	Зээл ашиглалт	Тусламж ашиглалт	Нийт дүн
Азийн хөгжлийн банк	377.2	91.3	468.4
Америкийн Нэгдсэн Улс	-	334.1	334.1
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	240.1	86.6	326.6
Бүгд Найрамдах Энэтхэг Улс	162.0	-	162.0
Европын сэргээн босголт, хөгжлийн банк	114.8	22.9	122.7
Дэлхийн банк	106.5	1.9	108.4
Бүгд Найрамдах Солонгос Улс	102.7	-	102.7
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	25.0	23.5	48.5
Австри	26.3	-	26.3
Польш	24.4	-	24.4
Европын хөрөнгө оруулалтын банк	16.0	-	16.0
Бүгд Найрамдах Франц Улс	15.0	-	15.0
Япон	15.0	-	15.0
Боловсролын Дэлхийн Түншлэл	-	9.5	9.5
Люксембург	-	2.7	2.7
Кувейт	-	0.5	0.5
Хөдөө аж ахуйн хөгжлийн олон улсын сан	0.1	-	0.1
Беларуьс	0.1	-	0.1
Нийт дүн	1,225.0	558.0	1,783.0

*Урьдчилсан гүйцэтгэлээр

Түүнчлэн, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын зээл, тусламжийн санхүүжилт 18.3 хувийг эзэлж, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих, 1008 айлын орон сууцны хороолол барих зэрэг томоохон төслүүдийг санхүүжүүлэх бол Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын тусламжаар санхүүжүүлэх Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл 18.7 хувийг, Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын зээлээр санхүүжүүлэх Газрын тосны үйлдвэр барих төсөл 9.1 хувийг, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын зээлээр санхүүжүүлэх 10 аймгийн дулааны станц барих зэрэг төслийн санхүүжилт нийт зээл, тусламжийн санхүүжилтийн 5.8 хувийг эзлэхээр байна.

Засгийн газрын 2024 оны гадаад зээл, тусламжийн ашиглалтыг бүтцийн хувьд авч үзвэл 1,326.0 тэрбум төгрөг буюу 74.4 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 270.0 тэрбум төгрөг буюу 15.1 хувийг дамжуулан зээлдүүлэх зардалд, 187.0 тэрбум төгрөг буюу 10.5 хувийг урсгал зардлын санхүүжилтээр тус тус ашиглахаар төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН,
ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ, ХУГАЦААНДАА
ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ӨР БА ХҮҮГИЙН
ТӨЛБӨРИЙН ДҮН

БҮЛЭГ ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ, НӨХЦӨЛ, ХУГАЦААНДАА ТӨЛӨГДӨӨГҮЙ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ӨР БА ХҮҮГИЙН ТӨЛБӨРИЙН ДҮН

2.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО, ЗОРИЛТ

Монгол Улсын Засгийн газраас өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн хангаж, 2023-2025 оны стратегийн баримт бичгийг 2022 оны 05 сарын 27-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулсан.

Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн хэрэгжилтийн хүрээнд Засгийн газраас сүүлийн 3 жилийн хугацаанд 4 удаагийн өрийн зохицуулалтыг амжилттайгаар хэрэгжүүлж, хугацаа нь тулаад байсан Чингис, Мазаалай, Хуралдай болон Гэрэгэ бондуудын нийт 2,396.2 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжүүлж, төсөвт дарамт учруулахгүйгээр 398.2 сая ам.долларын төлбөрийг улсын төсвийн боломжит мөнгөн хөрөнгөнөөс төлсөн байна. Ингэснээр 2012 оноос хойш Засгийн газрыг өрийн дарамтад оруулаад байсан арилжааны нөхцөлтэй зээллэгийн хэмжээ буурч, эргэн төлөлтийн хугацааг уртасгасан байна.

Засгийн газраас Монгол Улсын Хөгжлийн банкны (МУХБ) чанаргүй зээлийн эргэн төлөлтийг төлүүлэхтэй холбоотойгоор шат дараалсан оновчтой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд, Засгийн газрын өрийн баталгаанаас үүсэж болзошгүй эрсдэл буурч 2022 оны 6 дугаар сард Засгийн газрын өрийн баталгаатай БНХАУ-аас МУХБ-ны авсан гадаад зээлийг, 2022 оны 12 дугаар сард Самурай бондын төлбөрийг МУХБ-аас өөрийн хөрөнгөөр тус тус бүрэн төлж дуусгасан байна.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулах томоохон төслүүдийг хэрэгжүүлж дуусгаад байна. Энэхүү томоохон төслүүдэд, Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн “Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал барих төсөл” болон “ДЦС-4-ийг өргөтгөх төсөл”, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн “Улаанбаатар-Шинэ нисэх онгоцны буудал хоорондын хурдны зам барих төсөл” тус тус багтаж байгаа юм.

Засгийн газраас өрийн удирдлагын стратегийг чанд баримталж, оновчтой бодлого хэрэгжүүлсний үр дүнд, өнгөрөгч онуудад үүссэн олон улсын таагүй нөхцөл байдлуудад өрийн тусгай шаардлагыг бүрэн хангаж ажилласан. Улмаар, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа 2020 оны жилийн эцэст 62.3 хувь хүрч байсан бол 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр тус харьцаа 38.6 хувь болж буураад байна.

2.1.1 Засгийн газрын өрийн өнөөгийн байдал

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар, нэрлэсэн дүнгээр 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 62.3 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 38.6 хувьтай тэнцэж өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 23.7 хувиар буураад байна.

Хүснэгт 12. Засгийн газрын өрийн бүтцээрх үлдэгдэл 2020-2023 он, тэрбум төгрөг

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2020 он	2021 он	2022 он	2023* он
1. Засгийн газрын дотоод өр	1,136.6	657.3	1,035.5	234.1
1.1. Үнэт цаас	1,136.6	657.3	1,035.5	234.1
2. Засгийн газрын гадаад өр	24,851.4	24,693.3	29,641.6	30,273.4
2.1. Үнэт цаас	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7
2.2. Зээл	16,497.4	16,517.7	20,281.8	20,901.7
3. Бусад өр төлбөр	1,910.6	1,550.4	1,276.4	266.0
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	1,060.4	876.5	812.9	29.5
3.2. Концесс ("барих-шилжүүлэх")	850.2	673.9	463.5	236.5
4. Орон нутгийн зээллэг	-	17.2	12.3	-
4.1 НЗДТГ-ийн орон нутгийн зээллэг	-	17.2	12.3	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	27,898.6	26,918.1	31,965.8	30,773.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	23,024.3	21,837.3	27,691.6	26,584.1
<i>Төсвийн тогтвортой байдлын тухай тогтоосон өрийн хязгаар</i>	70%	70%	70%	65%
<i>Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ</i>	62.3%	50.8%	52.4%	38.6%


*Урьдчилсан гүйцэтгэлээр

Засгийн газрын өр 2020 оноос хойш буурсан голлох шалтгаан нь Засгийн газраас дунд хугацааны өрийн удирдлагын стратегийн баримт бичгийг чанд баримталж хугацаа тулаад байсан арилжааны нөхцөлтэй зээллэгийг дахин санхүүжүүлж, үлдэгдэл хэсгийг төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, төсвийн алдагдал нөхөх зорилгоор арилжааны зээл нэмж аваагүй ба бусад холбогдох зорилт арга хэмжээг хэрэгжүүлсэн. Түүнчлэн, 2023 оны 12 дугаар сард Монгол Улсын Хөгжлийн Банкны Япон Улсын санхүүгийн зах зээлд Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргасан "Самурай" бонд банкны өөрийн эх үүсвэрээс бүрэн төлж, Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан.

2.1.2 Засгийн газрын дотоод үнэт цаас

Сангийн яамны зүгээс Засгийн газрын үнэт цаасыг 2012 оны 12 дугаар сараас эхлэн Монголбанкаар дамжуулан, 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тус тус нээлттэй хэлбэрээр арилжаалж эхэлсэн.

График 29. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны хэлбэр, 2012-2017



Засгийн газар 2012-2017 онуудын хооронд 15.9 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг арилжаалсан бөгөөд үүний 70 хувь буюу 11.1 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголбанкаар, 10 хувь буюу 1.6 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр, үлдсэн 20 хувь буюу 3.2 их наяд төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг

хаалттай хэлбэрээр арилжаалсан байна.


Түүнчлэн 2013 онд арилжаалсан үнэт цаасны дундаж хүү 9.6 хувьтай тэнцэж байсан бол үнэт цаас гаргалтын хэмжээ, Төв банкны бодлогын хүү зэргээс хамаарч 2016 онд 16.9 хувь, 2017 онд 13.3 хувьд хүрч өсөж байжээ. Ийнхүү Засгийн газрын дотоод үнэт цаасны хүүгийн огцом өсөлтөөс шалтгаалан хүүгийн зардлын өсөлт өндөр түвшинд хүрсэн тул нэмж үнэт цаас гаргахыг 2017 оны дунд үеэс зогсоосон байдаг.

Харин Сангийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 145 дугаар тушаалын дагуу Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2022 оны 7 дугаар сард “Хадгаламжийн даатгалын корпораци сан”-д, 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 235 тоот тушаалын дагуу “Монгол Улсын Хөгжлийн банк”-нд 383.9 тэрбум төгрөгтэй тэнцэх үнэт цаасыг арилжаалсан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын газрын дотоод үнэт цаасыг “Монголын Хөрөнгийн бирж” ТӨХК-иар дамжуулан олон нийтэд арилжаалж эхлэх тухай танилцуулж Засгийн газрын хуралдааны 14 дүгээр тэмдэглэл гарсан. Үүнтэй холбоотой Монголын хөрөнгийн биржтэй хамтран Засгийн газрын 2019 оны 77

дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-нд нийцүүлэн хөрөнгө оруулагч нарт ашиглахад хялбар, ойлгомжтой, системийн аюулгүй байдлыг бүрэн хангасан дотоод арилжааны системийг бүрэн хөгжүүлээд байна.

График 30. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааны үлдэгдэл, 2016-2023



Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2020 оноос хуваарьт төлбөрийн үүргийг биелүүлсэнтэй холбоотойгоор буурч 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 234.1 тэрбум төгрөгтэй

тэнцэж байна.

2.1.3 Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 9,371.7 тэрбум төгрөг буюу 2,747.8 сая ам.доллартой тэнцэж байна.

Засгийн газар 2020 оноос өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичигт заасны дагуу гадаад үнэт цаасны өрийн зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд 2020 онд 600.0 сая ам.долларын Номад, 2021 онд 1.0 тэрбум ам.долларын Сенчири-1, 2023 онд 650.0 сая ам.долларын Сенчири-2 болон 350.0 сая ам.долларын Сенчири-3 төслүүдийг тус тус амжилттайгаар хэрэгжүүлсэн. Түүнчлэн улсын төсвөөс боломжит хэмжээгээр төлөх үйл ажиллагааг зохион байгуулж 2021 онд Мазаалай бондын үлдэгдэл 132.6 сая ам.доллар, 2022 онд Чингис бондын үлдэгдэл 137 сая ам.доллар, 2023 онд Гэрэгэ бондын үлдэгдэл 90.8 сая ам.долларыг тус тус төлж барагдуулсан байна.

Түүнчлэн, 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын гадаад бондын үлдэгдэл 2,931.7 сая ам.доллар байсан бол дээрх арга хэмжээг хэрэгжүүлсний дараа буюу 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2,747.8 сая ам.доллар болж бодитоор буурсан байна.

Хүснэгт 13. Гадаад үнэт цаас, 2023.12.31-УГ, тэрбум төгрөг

№	Гадаад үнэт цаас	Гаргасан хэмжээ /сая \$/	Гаргасан огноо	Хүү	Хугацаа	Зориулалт	Үлдэгдэл /тэрбум ₮/
1	Чингис-2022	1,000.0	2012/12	5.125%	10 жил	Төсөл хэрэгжүүлэх	-
2	Чингис-2017	500.0	2012/12	4.125%	5 жил	Төсөл хэрэгжүүлэх	-
3	Дим Сам	161.2	2015/06	7.500%	3 жил	Алдагдал нөхөх	-
4	Мазаалай	500.0	2016/04	10.875%	5 жил	Алдагдал нөхөх	-
5	Хуралдай	600.0	2017/03	8.750%	7 жил	Өрийн зохицуулалт	579.0
6	Гэрэгэ	800.0	2017/10	5.625%	5.5 жил	Өрийн зохицуулалт	0.0
7	Номад	600.0	2020/09	5.125%	5.5 жил	Өрийн зохицуулалт	1,971.4
8	Сенчири-2027	500.0	2021/06	3.500%	6 жил	Өрийн зохицуулалт	1,705.4
9	Сенчири-2031	500.0	2021/06	4.450%	10 жил	Өрийн зохицуулалт	1,705.4
10	Сенчири-2	650.0	2023/01	8.650%	5.5 жил	Өрийн зохицуулалт	2,216.9
11	Сенчири-3	350.0	2023/12	7.875%	5 жил	Өрийн зохицуулалт	1,193.6
НИЙТ							9,371.7


*Урьдчилсан гүйцэтгэлээр

2.1.4 Засгийн газрын гадаад зээл

Монгол Улсын Засгийн газрын зүгээс 1991 оноос 2023 оны хооронд нийт 8,706.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг 22 зээлдүүлэгчээс 340 төсөл хөтөлбөрт зарцуулсан. Үүнээс 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нийтдээ 2,163.9 сая ам.долларыг эргэн төлж 6,128.3 сая ам.доллартой тэнцэх үлдэгдэлтэй байна.

Түүнчлэн, 1991 оноос хойш авч ашигласан гадаад зээлийн хөрөнгийг төслийн зээлийн хүрээнд нийт 6,203.0 сая ам.доллар, хөтөлбөрийн зээлийн хүрээнд 2,559.4 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг авч ашигласан. Гадаад төслийн зээлийн ашиглалтын 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

График 31. Гадаад зээлийн ашиглалтыг салбар болон зориулалтаар, 2023.12.31-УГ



Мөн Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 46.6 хувийг дэд бүтцэд, 29.2 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 24.1 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 86.8 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 13.2 хувийг уул уурхай, эрчим хүчний салбарууд тус тус эзэлж байна. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл бодитоор жил бүр өсөж байгаа бөгөөд 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл 3.0 тэрбум ам.доллар, гадаад зээлийн үлдэгдэл 20,901.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 14. Гадаад зээлийн үлдэгдэл төрлөөр, 2019-2023.12.31 УГ, тэрбум төгрөг

Төрөл	2019	2020	2021	2022	2023
Хөтөлбөрийн зээл	3,691.5	5,560.3	5,450.7	6,551.9	6,719.3
Төслийн зээл	9,109.3	10,937.0	11,066.9	13,729.9	14,182.4
НИЙТ	12,800.8	16,497.4	16,517.6	20,281.8	20,901.7

*Урьдчилсан гүйцэтгэлээр

Цаашид Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хүрээнд Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач

холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллана.

2.1.5 Засгийн газрын өрийн баталгаа

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сард батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад баталгаа гаргуулагч болон төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага хуульчлагдаж, өрийн баталгаа гаргуулах хүсэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх, төсөл арга хэмжээнд хяналт тавих зэрэг хууль эрх зүйн орчин бүрдсэн. Тус хууль батлагдахаас өмнө Засгийн газрын зүгээс Монгол Улсын Хөгжлийн банкны дунд хугацааны Евро бонд, Самурай бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл, “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн санхүүжилт зэрэг нийтдээ 2.7 их наяд төгрөгтэй тэнцэх зээллэгүүдэд баталгааг гаргасан байдаг.

Өрийн удирдлагын тухай хуульд баталгаа гаргуулагч байгууллага нь сүүлийн 3 жил ашигтай ажилласан, хугацаа хэтэрсэн өргүй, зээлдүүлэгч байгууллагатай нэгдмэл сонирхолгүй, хэрэгжүүлж буй төслийн бэлтгэл ажил хангагдсан буюу техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байх, холбогдох мэдээлэл, тайлан тооцоо, баримт бичгийг бүрдүүлсэн, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай байх зэрэг шаардлагуудыг хангахаар тусгагдсан. Ингэснээр Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах, төсөвт учирч буй болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах хөшүүрэг болж өгсөн. Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаас хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаас, “Эрдэнэс Монгол” ХК-ийн АХБ-аас авсан зээлүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.

Хүснэгт 15. Засгийн газрын баталгаа, 2023.12.31 УГ

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Валют	2023.12.31	
				Үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг
1	Эрдэнэс Монгол ХК	Азийн Хөгжлийн Банк	Ам.доллар	9.1	29.5
НИЙТ					29.5

*Урьдчилсан гүйцэтгэлээр


Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,060.4 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс Засгийн газартай хамтран өрийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж өөрийн эх үүсвэрээс хугацаа тулаад байсан “Евробонд” болон Засгийн газрын өрийн баталгаатай “Самурай” бондуудыг амжилттай төлж барагдуулснаар Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр

буурч, 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 29.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2.1.6 Барих-шилжүүлэх төрлийн концесс

Улсын төсвөөс 2014-2017 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 2.3 их наяд төгрөгтэй тэнцэх 40 концессын гэрээ болон орон нутгийн төсвөөс 2013-2016 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 133.4 тэрбум төгрөгтэй тэнцэх 50 концессын гэрээ тус тус байгуулагдсан байна. “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулагдсан дүнгээр Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөж, ирэх онуудын төсөвт ирэх төлбөрийн дарамт эрс нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор барих-шилжүүлэх концессын гэрээг дахиж байгуулахгүй байх, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл арга хэмжээг зогсоох шийдвэр гарсан.

**График 32. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл,
2023.12.31 УГ тэрбум төгрөг**



Эх сурвалж: Сангийн яам

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчлагдсан

бөгөөд мөн

хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасан. Сангийн яамны зүгээс Эдийн засгийн хөгжлийн яам болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан концессын ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг улирал бүр авч Засгийн газрын өрд бүртгэж байна. Харин Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Өрийн удирдлагын хуулийн дээрх заалтад өөрчлөлт орж Засгийн газрын өрд тооцож бүртгэх шаардлагагүй болсон тул 2024 оноос эхлэн барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдлийг Засгийн газрын өрийн үлдэгдэлд оруулж тайлагнахгүй байхаар зохицуулагдсан. Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 236.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2.2. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг Монгол Улсын Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК болон “МИАТ” ТӨХК-уудын зээл авсан байгууллагууд эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэсэн.

МИАТ ТӨХК-д гаргасан Засгийн газрын баталгаа - Бойнг агаарын хөлөг худалдан авсан зээл.

МИАТ ТӨХК нь 2013 оны 12 сарын 24-ний өдөр 121.4 сая ам.долларын 5, 7, 10 жилийн хугацаатай 3 дэд хэсгээс бүрдэх зээллэг хийсэн бөгөөд Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МИАТ ТӨХК нь зээлийн эх үүсвэрээр Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авсан бөгөөд зээлийг 2022 оны 06 дугаар сард бүрэн төлөгдөж дууссан.

МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа - “Самурай” үнэт цаас.

МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иенийн “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ нь “Самурай” үнэт цаасны эх үүсвэрийг “ТОСК” ТӨҮГ, Эрэл ХХК, “Хөтөл” ХХК зэрэг байгууллагуудын 5 төрлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд ашигласан байдаг. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасыг 2023 оны 12 дугаар сард хөрөнгө оруулагчдад бүрэн төлсөн.

МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа. - БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл

МУХБ 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 162.0 сая ам.долларын 8 жилийн хугацаатай, 6.0 хувийн хүүтэй, зээл авсан бөгөөд Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ уг зээлийн эх үүсвэрийг Амгалан дулааны станц, Баянхонгор-Алтай чиглэлийн 128 км авто зам, Улаангом-Наранбулаг чиглэлийн 90 км авто зам зэрэг нийт 11 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан. Зээлийг 2022 оны 09 сард бүрэн төлж барагдуулсан байна.

“Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа. - Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл

“Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын Libor+0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн

хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. “Эрдэнэс Монгол” ХХК уг зээлийн эх үүсвэрийг компанийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөлд ашиглаж байна. Зээлийн үлдэгдэл 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 9.1 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

Шинээр үүсгэх болзошгүй өр төлбөрийн талаар

Улсын Их Хурлын 2023 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 90 дүгээр тогтоол, 2024 оны “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” 17 дугаар тогтоолыг тус тус баталсан. Үүний дагуу Засгийн газраас 2024 онд МУХБ-ны дамжуулан зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Чойбалсан ДЦС-ын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-д Засгийн газрын өрийн баталгаа гаргах төлөвлөгөөтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН
ҮЛДЭГДЛИЙН НИЙТ ДҮН, ЭНЭ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ДАРААГИЙН
ЖИЛИЙН ХУГАЦААН ДАХЬ ТУХАЙН САНГИЙН ЭХ
ҮҮСВЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ҮНЭЛГЭЭ

БҮЛЭГ ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ҮЛДЭГДЛИЙН НИЙТ ДҮН, ЭНЭ НЬ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ДАРААГИЙН ЖИЛИЙН ХУГАЦААН ДАХЬ ТУХАЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ҮНЭЛГЭЭ

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсанаар төсвийн тогтвортой байдлыг хангах Төсвийн тогтворжуулалтын сан (ТТС)-г байгуулсан. Төсвийн тогтворжуулалтын сан нь нэгдсэн төсвийн дунд болон урт хугацааны тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах, төсвийн тэнцвэржүүлсэн горимыг хэрэгжүүлэхэд санхүүгийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2-т зааснаар “Төсвийн тогтворжуулалтын сан”-г татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг, Засгийн газрын нөөц сангийн өмнөх жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр, төсвийн тогтворжуулалтын сангийн санхүүгийн үйл ажиллагаанаас олсон орлого болон бусад орлогоос бүрдүүлнэ.

3.1 ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД ШИЛЖҮҮЛСЭН ЭРДЭС, БАЯЛГИЙН ОРЛОГО, САНГИЙН ЗАРЛАГА

Төсвийн тогтворжуулалтын санд 2020 онд 52.4 тэрбум төгрөг, 2021 онд 728.8 тэрбум төгрөг, 2022 онд 1,415.0 тэрбум төгрөг, 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 653.4 тэрбум төгрөгийн орлого орж 2020-2023 оны хугацаанд нийт 2.8 их наяд төгрөг төвлөрсөн байна.

Хүснэгт 16. ТТС-ийн орлого, зарлага, хуримтлал, тэрбум төгрөг

	2020	2021	2022	2023 УГ
ТТС-ийн орлого	52.4	728.8	1,415.0	653.4
АМНАТ	47.4	561.8	1,176.7	560.6
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	5.0	166.9	238.2	92.8
ТТС-ийн зарлага (Улсын төсөвт шилжүүлэг)	138.8	728.8	751.7	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Үүнээс дийлэнх буюу 82 орчим хувийг татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон АМНАТ-ын орлого бүрдүүлсэн бол 18 орчим хувийг уул уурхайн компаниудаас төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого бүрдүүлсэн байна. Засгийн газрын зарцуулагдаагүй нөөцийн үлдэгдлийн хувьд санд 2022

онд 21.3 сая төгрөг төвлөрүүлсэн бол 2020, 2021, 2023 онуудад санд орлого оруулаагүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4-т ТТС-ийн хөрөнгөөс тодорхой нөхцөл байдлын улмаас үүссэн төсвийн орлогын тасалдал болон тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болохоор заасан ба сангийн хуримтлалаас 2020 онд 138.8 тэрбум төгрөг, 2021 онд 728.8 тэрбум төгрөг, 2022 онд 751.7 тэрбум төгрөгийг улсын төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар тус тус шилжүүлсэн байна.

Харин 2023 оны нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэлд төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан тул тус сангаас зарцуулалт гаргаагүй болно.

3.2 ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНГИЙН ХУРИМТЛАЛЫН ТАЛААРХ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

2022 онд ТТС-д нийт 1,415.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрснөөс 751.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлснээр 663.3 тэрбум төгрөг хуримтлагдсан байна. Харин 2023 онд ТТС-д 653.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрснөөс зарцуулалт хийгдээгүй тул 2023 оны байдлаар ТТС-д нийтдээ 1,316.7 тэрбум төгрөг хуримтлагдсан байна.

Хүснэгт 17. ТТС-ийн хуримтлал, тэрбум төгрөг

	2020	2021	2022	2023 УГ
ТТС-ийн хуримтлал	0.0	0.0	663.3	1,316.7

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2-т “ТТС-ийн хөрөнгө нь дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас доошгүй байна” гэж заасан байсныг төсвийн алдагдлыг үе шаттай бууруулах, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бууруулах зорилтын хүрээнд 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлтөөр дээрх хуулийн шаардлагыг хүчингүй болгосон.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

СОНГУУЛИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН
ШИЙДВЭР НЬ ДАРААГИЙН ЖИЛҮҮДИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН
ТӨЛӨВ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮЗҮҮЛЭЛТ

БҮЛЭГ ДӨРӨВ. СОНГУУЛИЙН ЖИЛД ЗАСГИЙН ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ ДАРААГИЙН ЖИЛҮҮДИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн жилд УИХ болон Засгийн газраас баталж хэрэгжүүлсэн шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд төсөвт дараах нөлөөллийг үзүүлэхээр байна.

Хүснэгт 18. Сонгуулийн жилд гарсан шийдвэрийн төсөвт үзүүлэх нөлөөллийн хэмжээ, тэрбум төгрөг

Арга хэмжээ зардал	2024 оны суурьтай харьцуулахад нэмэгдэх зардал			
	2025 онд	2026 онд	2027 онд	2028 онд
Сонгуулийн жилд батлагдсан хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах нийт хөрөнгө	469.2	19.8	15.9	10.0

Эх сурвалж: Сангийн яам

Сонгуулийн жилд батлагдсан томоохон арга хэмжээ:

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх: Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10-20 хувь нэмэгдүүлэх, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын дагуу орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргаа, төрийн үйлчилгээ болон улс төрийн албан хаагчдад 20-40 хувийн орон нутгийн нэмэгдэл олгоход нийт 889.8 тэрбум төгрөг 2024 оны төсөвт тусгасан.

НДС-аас олгох тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх: 2024 оны 4 дүгээр сарын 1-ны өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 100.0 мянган төгрөгөөр нэмж байгаатай холбоотойгоор 2025 оны 1 дүгээр улиралд төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож тусгана.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх: Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмж байгаатай холбоотойгоор 2025 оны 1 дүгээр улиралд төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож тусгах.

СӨБ эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардал: Үндэсний статистикийн хорооны хүн амын хэтийн төлөв /дунд хувилбар 16/ тооцоолол болон Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын дагуу СӨБ-ийн байгууллагад суралцагчдын тооны өсөлттэй холбоотойгоор зардал нэмэгдэхээр байна.

ЕБС-ийн суралцагчид боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардал: Үндэсний статистикийн хорооны хүн амын хэтийн төлөв /дунд хувилбар 16/ тооцоолол болон Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын дагуу ЕБС-ийн

байгууллагад суралцагчдын тооны өсөлттэй холбоотойгоор зардал нэмэгдэхээр байна.

Эдгээр арга хэмжээ нь 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн тул 2025 оны төсөвт 1-р улирлын төсвийг нэмж тусгах шаардлагатай байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль: УИХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 19-ны чуулганаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж 2024 оны 5 дугаар сарын 1-нд тус хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолыг баталсан. Үндэсний баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлжсөн сантай байна. Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулахаар хуульд заасан. Ирээдүйн өв сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкн дахь Ирээдүйн өв сангийн валютын дансанд байршуулна. Ирээдүйн өв сан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг, сангийн хөрөнгө оруулалтын орлогоос бүрдүүлнэ. Түүнчлэн, Ирээдүйн өв санд хуримтлагдсан мөнгийг хөрөнгө оруулж, өсгөж арвижуулна.

Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлнэ. Хуримтлалын сангийн орлого нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмших хувьцааны 34 хувьд ногдох ногдол ашгийн орлогоос бүрдэнэ.

Хөгжлийн сан нь Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ. Тодруулбал, Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан нийгэм, эдийн засгийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Хөгжлийн сангийн эх үүсвэр нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд Төсвийн тогтворжуулалтын сангийн тухайн жилийн орлогын 50 хувиас бүрдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ.

**ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ**

БҮЛЭГ ТАВ. ИРЭХ ДӨРВӨН ЖИЛИЙН МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

5.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТӨСӨӨЛӨЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүн.

Эдийн засаг 2024 онд 6.0 орчим хувиар өсөхөөр төсөөлж байна. Оюутолгойн эрдсийн өндөр агуулгатай гүний уурхайн олборлолт үргэлжилснээр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний олборлолт нэмэгдэхээр байгаа нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг дэмжихээр хүлээгдэж байна. Мөн уул уурхайн салбарын дам нөлөөгөөр тээврийн салбарын үйлдвэрлэл тогтвортой байх бол гадаадын жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүд 2024 оны сүүлийн хагас жилээс аялал жуулчлалын салбарт эерэг нөлөө үзүүлэхээр байна. Боловсруулах салбарт 2023 онд тоног төхөөрөмжийн импорт нэмэгдсэн нөлөөгөөр уул уурхайн бус, боловсруулах салбаруудын гарц нэмэгдэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас том малын зүй бус хорогдол 2023 оны түвшнээс давж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшиж болзошгүй байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж 2024 оны 2 дугаар улиралд нэмэгдсэнтэй холбоотойгоор өрхийн хэрэглээ өсөх хүлээлттэй байна. Дотоод эрэлт, өрхийн хэрэглээ эрчимжсэнээр худалдаа, үйлчилгээний салбарууд эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлэхээр байна.

Сүүлийн 2 жил дараалан өвөлжилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн салбарын 90 гаруй хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн үйлдвэрлэл буурах, өсөлтийг хязгаарлах томоохон эрсдэл болж байна.

Гадаад худалдаа. 2024 онд экспорт 17.4 тэрбум ам.доллар, импорт 11.3 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 6.1 тэрбум ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна. Монгол Улсын Засгийн газраас экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ БНХАУ-ын хойд хэсгийн эдийн засгийн өсөлт гадаад эрэлтийг тэтгэснээр экспортын өсөлт хадгалагдаж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. Экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох зэсийн баяжмал, газрын тосны дэлхийн зах зээл дээрх үнэ өсөхөөр хүлээгдэж байгаа бол коксжих нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурахаар хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч нийт нүүрсэнд агуулагдах чанар сайтай баяжуулсан нүүрсний хэмжээ нэмэгдэж байгаагаас гадна нүүрс, төмрийн хүдэр, баяжмалыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж эхэлсэн нь хилийн үнэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин өрхийн орлого, зээл олголт нэмэгдэж, эдийн засгийн өсөлт тогтвортой байх төлөвтэй байгаа нь импортын барааны эрэлтийг өсгөхөөр байна.

Инфляц. Инфляц 2024 оны 3 дугаар сард 7 хувь гарсан бол 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшинд байх төлөвтэй байна. Олон улсад өрнөж буй геополитикийн тогтворгүй байдалтай холбоотой дэлхийн чингэлэг тээврийн зардал нэмэгдэж байгаа нь манай улсын импортын барааны үнэ өсөж болзошгүй байна. Мөн өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор малын зүй бус хорогдол нэмэгдэж байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантайгаар махны үнэ нэмэгдэх, улмаар хүнсний инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж байна.

Хүснэгт 19. Монгол Улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, 2025-2027

	2025	2026	2027
ДНБ-ий оны үнээр, тэрбум төгрөг	95,014	104,706	116,772
ДНБ-ий бодит өсөлт, хувь	8.0	6.5	6.5
Уул уурхайн салбарын бодит өсөлт	16.2	5.0	2.9
Уул уурхайн бус салбарын бодит өсөлт	6.7	6.7	7.1
Экспортын хэмжээ, нийт	19,250	21,050	22,750
Импортын хэмжээ, нийт	12,500	13,750	15,120
Гадаад тэнцэл, сая ам.доллар	6,750	7,300	7,630
Хэрэглээний үнийн өсөлт, жилийн дундаж өсөлт	6.0	4.0	3.0

Эх сурвалж: Эдийн засаг хөгжлийн яам

5.2. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2025 онд 29,400.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 30.9 хувьд хүрэхээр байгаа бөгөөд 2027 онд 34,460.3 тэрбум төгрөг хүрч өсөхөөр байна.

Төсвийн орлогын өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлс.

Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ирэх 3 жилд дунджаар 10 хувиар өсөхөөр байгаа бөгөөд орлогын өсөлтөд ДНБ-ий бодит өсөлт, импортын өсөлт, эрдэст бүтээгдэхүүний экспортын хэмжээ, үнэ зэрэг эдийн засгийн хүчин зүйлс нөлөөлж байна.

График 33. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын урьдчилсан төсөөлөл, тэрбум төгрөг




Эх сурвалж: Сангийн яам

5.3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨСӨӨЛӨЛ

Ирэх жилүүдийн төсвийн зарлагын төсөөллийг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн тусгай шаардлагууд хангагдаж байхаар, мөн УИХ-аар батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсрууллаа.

График 34. Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

Төсөвт ирэх ачаалал, хэрэгцээ шаардлага: Хүн амын өсөлт, үнэ ханшны өөрчлөлт, түүнчлэн Улсын Их Хурал, Засгийн газрын 2024 оноос өмнө гаргасан шийдвэрийн төсвийн зарлагад нөлөөлөх үр дагавар бүхий шийдвэр, арга хэмжээнүүд нь төсвийн урсгал зарлагыг 2025 онд 1,388.4 тэрбум төгрөг, 2026 онд 1,241.1 тэрбум төгрөг, 2027 онд 1,226.8 тэрбум төгрөг, 2028 онд 1,615.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх урьдчилсан тооцоолол байна.

Хүснэгт 20. Төсвийн зардлын хэрэгцээний төсөөлөл, сая төгрөг

АРГА ХЭМЖЭЭ ЗАРДАЛ	2024 оны суурьтай харьцуулахад нэмэгдэх зардал			
	2025 он	2026 он	2027 он	2028 он
НИЙТ ЗАРДАЛ	1,388.4	1,241.1	1,226.8	1,615.2
2024 оноос өмнө батлагдсан хууль тогтоомжийн дагуу хэрэгжих арга хэмжээнүүд	1,238.5	1,071.2	1,040.2	1,412.2
Статистик, хүн ам зүйн өөрчлөлт болон хөрөнгө оруулалтаас шалтгаалан нэмэгдэх зардал, арга хэмжээ:	149.9	169.9	186.7	202.9

Эх сурвалж: Сангийн яам

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ
ТӨСӨӨЛӨЛ НЬ УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛАГДСАН ДУНД
ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ЭСХҮЛ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД
НИЙЦЭЖ БАЙГАА ТАЛААР

БҮЛЭГ ЗУРГАА. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСӨӨЛӨЛ НЬ УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛАГДСАН ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, ЭСХҮЛ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГАД НИЙЦЭЖ БАЙГАА ТАЛААРХ ТАЙЛБАР

6.1. ТӨСВИЙН БОДЛОГЫН ҮР ДҮН НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ /2020-2024/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг тодорхойлсон бөгөөд тус хуулийн 19 дүгээр зүйл буюу хуулийг дагаж журмын хүрээнд тусгай шаардлагуудыг үе шаттай мөрдөж байна.

- Төсвийн орлогын тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх” гэж заасны дагуу 2020-2024 оны төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож ирсэн. Ингэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.2-т заасны дагуу тухайн жилийн гол нэр төрлийн эрдэс баялгийг тодорхойлж, 11.1.3.а-д заасны дагуу тэнцвэржүүлсэн үнийг тооцоолсон. Дараах хүснэгтээр 2020-2024 оны төсвийн гол нэр төрлийн эрдэс баялаг, түүний тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн орлогын мэдээллийг үзүүлээ.

Хүснэгт 21. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, 2020-2024 он

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гол нэр төрлийн эрдэс баялаг	
		Зэс	Нүүрс
2020 он гүйц			
Тэнцвэржүүлсэн үнэ	\$/тн	6,290.5	75.5
Зах зээлийн үнэ	\$/тн	6,168.5	74.2
Тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төг	9,463.8	
2021 он гүйц			
Тэнцвэржүүлсэн үнэ	\$/тн	5,456.1	76.3
Зах зээлийн үнэ	\$/тн	9,314.4	172.4
Тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төг	12,711.4	
2022 он гүйц			
Тэнцвэржүүлсэн үнэ	\$/тн	6,306.0	73.4
Зах зээлийн үнэ	\$/тн	8,813.9	204.4
Тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төг	17,126.9	
2023 он урьдчилсан гүйц			
Тэнцвэржүүлсэн үнэ	\$/тн	8,386.7	110.8
Зах зээлийн үнэ	\$/тн	8,482.8	127.8
Тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төг	23,217.9	
2024 он төлөвлөгөө			

Тэнцвэржүүлсэн үнэ	\$/тн	7,386.6	182.5
Зах зээлийн үнэ	\$/тн	9,000.0	140.0
Тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төг	25,855.1	

Эх сурвалж: Сангийн яам

2. **Төсвийн тэнцлийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2024 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж тусгасан.

Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, ДНБ-д эзлэх хувь

	2021	2022	2023*	2024* *
Хуулиар тогтоосон хязгаар	-8.8%	-5.1%	-3.6%	-2.8%
Гүйцэтгэл	-6.7%	-1.9%	1.3%	-2.0%

Эх сурвалж: Сангийн яам

Тус тусгай шаардлагыг 2021, 2022 оны гүйцэтгэл, 2023 оны урьдчилсан гүйцэтгэл, 2024 оны батлагдсан төсвийн хувьд хангасан байна.

3. **Зарлагын өсөлтийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан бөгөөд тус тусгай шаардлагыг 2013 оны төсвийн жилээс эхлэн мөрдөж эхэлсэн.

Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлт, хувиар

Өсөлт	2021	2022	2023*	2024**
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	8.5%	5.2%	11.0%	22.5%
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	17.4%	17.9%	14.6%	12.9%
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь, гүйцэтгэлээр	-4.3%	15.3%	14.3%	22.3%


Эх сурвалж: Сангийн яам

2021-2024 онд төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлагыг бүрэн хангасан буюу нэгдсэн төсвийн зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт болон тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрээгүй байна.

4. **Өрийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т төсөвт баримтлах өрийн тусгай шаардлагыг тодорхойлсон.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2020 оноос 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны

График 35. Засгийн газрын өрийн хэмжээ, 2020-2023



төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрэхгүй байхаар заасан байдаг. Засгийн газрын өрийн харьцаа үзүүлэлт 2020 онд 62.3 хувь, 2021 онд 50.8 хувь, 2022 онд 52.4 хувь, 2023 онд 38.6 хувьтай тус тус тэнцэж Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

6.2. ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ НЬ ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙ ТАЛААР

Ирэх жилүүдийн төсвийн төсөөллийн хувьд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд дараах байдлаар хангагдахаар байна.

- 1. Төсвийн орлогын тусгай шаардлага:** Ирэх гурван жилд гол нэр төрлийн эрдэс баялагт зэс болон нүүрс хамаарна гэж тооцож төсвийн орлогын төсөөллийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Зэсийн тэнцвэржүүлсэн үнэ 2025 онд тонн тутамд 7,491.7 ам.доллар, 2026 онд 7,591.2 ам.доллар, 2027 онд 7,679.3 ам.доллар байхаар байна. Харин нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ 2025 онд тонн тутамд 129.0 ам.доллар, 2026 онд 130.7 ам.доллар, 2027 онд 132.9 ам.доллар байхаар байна.
- 2. Төсвийн тэнцлийн тусгай шаардлага:** 2025-2028 онд төсвийн тэнцлийг ДНБ-ий 2 хувьтай тэнцэхээр төсөөлж байгаа бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасан төсвийн тэнцлийн тусгай шаардлагыг хангахаар байна.

Хүснэгт 24. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл, ДНБ-д эзлэх хувь

		2025	2026	2027
1	Хуулиар тогтоосон хязгаар	-2%	-2%	-2%
2	Төсөөлөл	-2%	-1.5%	-1%

Эх сурвалж: Сангийн яам

- 3. Төсвийн зарлагын өсөлтийн тусгай шаардлага:** Ирэх жилүүдийн төсвийн зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь болон тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхээргүй байна.

Хүснэгт 25. Нэгдсэн төсвийн зарлагын өсөлтийн төсөөлөл, хувиар

Өсөлт	2025	2026	2027
Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	14.5%	14.9%	15.0%
Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	12.6%	12.4%	12.5%
Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь, төсөөлөл	14.4%	7.1%	6.3%

Эх сурвалж: Сангийн яам

- 4. Өрийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлагын дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 60 хувиас хэтрэхгүй байх шаардлагатай.

Дээрх шаардлагын дагуу тус харьцаа үзүүлэлтийг 2025-2028 онд ДНБ-ний 60 хувиас хэтрэхгүй байхаар төсөөллөө.

Хүснэгт 26. Засгийн газрын өрийн төсөөлөл, өнөөгийн үнэ цэнээр, ДНБ-д эзлэх хувь

		2025	2026	2027
1	Хуулиар тогтоосон хязгаар	60%	60%	60%
2	Төсөөлөл	60%	60%	60%

Эх сурвалж: Сангийн яам

6.3. ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛТЭЙ НИЙЦЭЖ БУЙ ТАЛААР

Ирэх жилүүдийн төсвийн төсөөллийг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр УИХ-аар батлагдсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсөөллийн тухай хуультай нийцүүлэн боловсрууллаа. 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тогтоосон төсвийн төсөөлөлтэй нийцтэй буюу хуульд заасан хэмжээнд байхаар төсөөллөө.